



ГОЛОМТ БАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2008



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын мэндчилгээ	2
Гүйцэтгэх Захирлын мэндчилгээ	4
Эдийн засгийн тойм	7
Байгууллагын хөгжил	12
Хэтийн Зорилго, Эрхэм Зорилго	12
Бүтэц зохион байгуулалт	13
Компанийн засаглал	14
Хүний нөөц	17
Дэд бүтэц	18
Үйл ажиллагааны тойм	20
Иргэдэд хандсан бизнесийн үйл ажиллагаа	20
Байгууллагад хандсан бизнесийн үйл ажиллагаа	22
Худалдааны санхүүжилт, олон улсын төлбөр тооцоо	23
Нөөцийн болон арилжааны үйл ажиллагаа	24
Санхүүгийн үр дүн	25
Эрсдэлийн удирдлага ба хяналт	29
Нийгэмд чиглэсэн арга хэмжээ	37
Бүтээгдэхүүн, үйлчилгээ	38
Банкны салбар нэгжүүдийн хаяг	40

Хараат бус аудиторын дүгнэлт	44
Санхүүгийн тайлангууд	45

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын мэндчилгээ



Д.Баясгалан

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

... Олон улсын болон дотоодын эдийн засагт ихээхэн сорилт, бэрхшээл тулгарсан хэдий ч, Голомт банк 14 жилийн турш тасралтгүй үзүүлсээр ирсэн өндөр ашгийн үзүүлэлтээ бататгаж чадлаа ...

Эрхэм хүндэт хувь нийлүүлэгч, харилцагч, түнш байгууллагууд, ажиллагсад аа

Голомт банкныхаа 2008 оны үйл ажиллагааны үр дүнг Төлөөлөн Удирдах Зөвлөлийг төлөөлөн та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Өнгөрөгч 2008 он АНУ-аас эхлээд дэлхий нийт төдийгүй Монгол орны хувьд ч санхүүгийн бэрхшээлтэй жил боллоо.

Эд хөрөнгийн үнийн хөөрөгдөл, зээлийг хавтгайруулан олгох явдал, эрсдэл өндөртэй санхүүгийн үйл ажиллагаанууд, санхүүгийн системийн сул бөгөөд хангалтгүй зохицуулалт, зохисгүй сангийн бодлого удаан үргэлжилсний эцэст олон улсын санхүүгийн систем эмх замбараагүй байдалд орж, улмаар худалдаа арилжааны салбарт огцом уналт гарснаар ирэх 2009 он 1829 оноос хойшхи олон улсын санхүүгийн зах зээлд хамгийн таагүй гэгдэж буй (1931 онтой хамт) хоёр жилийн нэг болох төлөвтэй байна.

Дотоодын эдийн засгийн өсөлтийн хурд оны эхний хагаст эрчтэй байснаа дэлхийн зах зээлд нийлүүлдэг бараа бүтээгдэхүүний үнийн уналтаас шалтгаалж оны сүүлийн хагаст нэлээд саарсан. Ялангуяа экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох зэсийн үнэ 70 хувиар, ноолуурын үнэ унасан зэрэг нь Монгол Улсын эдийн засагт шууд нөлөөлж, улмаар төсвийн алдагдал ДНБ-ий 5 хувьтай тэнцэхүйц түвшинд хүрлээ.

Ийнхүү олон улсын болон дотоодын эдийн засагт ихээхэн сорилт, бэрхшээл тулгарсан хэдий ч, Голомт Банк 14 жилийн турш үзүүлж ирсэн ашгийн өндөр үзүүлэлтээ бататгаж чадлаа.

Эдийн засгийн ээдрээт энэ цаг үед активын өсөлтөөс илүүтэйгээр зээлийн чанарт онцгой анхаарч, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Нийт активийн хэмжээ 2008 онд 652 тэрбум төгрөгөөс

7 хувиар өсч 697 тэрбум төгрөгт, татварын дараах ашиг 65 хувиар өсч 12.2 тэрбум төгрөгт, 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө 32 хувиар өсч 50.9 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Мөн түүнчлэн, манай эрхэм түнш Кредит Свисстэй байгуулсан хөрөнгө оруулалтын хэлцлийн үр дүнд манай өөрийн хөрөнгө 12.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 63.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Түүнчлэн бид дээр дурьдсан амжилтаас гадна компанийн зохистой удирдлага, үйл ажиллагааны зарчим, журмуудыг сайжруулах чиглэлээр дорвитой ахиц гаргалаа.

Мөн оны 12 дугаар сард Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний үүрэгт ажлыг 4 жил амжилттай гүйцэтгэсэн ноён М.Мөнхжаргал өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, түүний оронд банкны анхны үүсгэн байгуулагчдын нэг ноён М.Зоригт УИХ-ын гишүүний албыг 4 жил амжилттай хашиж байгаад Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр эргэн ирлээ. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцож, үнэтэй санал зөвлөгөө өгч ирсэн ноён М.Мөнхжаргалд талархал илэрхийлье.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын хувьд өнгөрч буй онд банкныхаа үйл ажиллагаа, амжилтад үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүст жил бүр талархал илэрхийлдэг уламжлалтай. Урьд хожид тохиолдож байгаагүй онцгой их сорилтын жил банкны үйл ажиллагааг чин сэтгэлийн угаас хичээл зүтгэл гарган удирдан зохион байгуулсан хүмүүст талархал илэрхийлэх нь нэн чухал юм.

Иймд юун түрүүнд манай банкныг сонгож үйлчлүүлдэг харилцагчид болон бидэнд итгэл хүлээлгэсээр ирсэн Монголынхоо нийт ард түмэн, аж ахуйн нэгж байгууллагууд болон хамтран ажилладаг банкууддаа талархал илэрхийлье. Цаашлаад бидний үйл ажиллагааг дэмжиж, хэзээ ямагт чиглүүлж ирсэн Сангийн сайд болон тус яамны ажилтнууд, Монголбанкны ерөнхийлөгч болон тус банкны ажиллагсдад, мөн манай банкны амжилтын үндэс болсон итгэл зүтгэлтэй ажилтан албан хаагчиддаа, эцэст нь банкны хувь нийлүүлэгч “Бодь интернэшнл” ХХК-д талархал илэрхийлье.

Дүгнэж хэлэхэд, аргын тооллын 2009 он, билгийн тооллын Үхэр жил Монголд төдийгүй дэлхий дахинаа их сорилтын жил болох нь нэгэнт тодорхой бөгөөд өсөлтийн хурд саарч, шинэ зөв бодлого шаардагдаж буй энэ үед Голомт Банк зорилгодоо үнэнч байж, санхүүгийн хүчирхэг байдлаараа өмнөө тулгарах бэрхшээлүүдийг сөрөн зогсож харилцагч үйлчлүүлэгчиддээ хамгийн сайн үйлчилгээг хүргэсээр байх болно.



Д.Баясгалан

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

Гүйцэтгэх Захирлын МЭНДЧИЛГЭЭ



Жон П. Финиган
Гүйцэтгэх захирал

... Банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш тасралтгүй амжилттай ажилласан арван дөрөв дэх жилд үйл ажиллагааны татварын өмнөх ашиг 2007 онд хүрсэн 9.2 тэрбум төгрөгийн амжилтаас 69 хувиар буюу 6.3 тэрбумаар өсч, нийт 15.5 тэрбум болж өслөө. Улсад 3.3 тэрбум төгрөгийн орлогын албан татвар буюу урьд жилээс 2 дахин өссөн дүнгээр татвар төлсний дараа, татварын дараах ашиг өмнөх жилээс 65 хувиар өсч буюу 12.2 тэрбум төгрөг болмоо.

Эрхэм харилцагч, түнш, хувь нийлүүлэгч, хамтран ажиллагсад аа

2008 он нь дэлхийн санхүүгийн системд өмнө тохиож байгаагүй томоохон бэрхшээл тулгарч, улмаар оны сүүлийн саруудад эдийн засгийн хямрал болон даамжирсан онцлог жил болсон гэдгийг бид бүхэн сайн мэдэж байгаа билээ.

Дотоодын банкны системийн нийт эх үүсвэрийн дөнгөж 11 хувь нь гадаадаас орж ирсэн эх үүсвэр эзэлдэг буюу үүний ихэнх нь олон улсын санхүүгийн томоохон байгууллагуудаас орж ирсэн дунд хугацааны эх үүсвэр (тухайлбал Голомт Банкны хувьд үнэ цэнэтэй түншлэгч Кредит Свисстэй байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээгээр тохирсон 5 жилийн хугацаатай эх үүсвэр) эзэлж буй юм. Монголын банкны систем гадаад эх үүсвэрээс хамаарал багатай хэдий ч дэлхийн зах зээл дээрх түүхий эд, бараа материалын үнийн уналт нь улс орны худалдааны тэнцэлд муугаар нөлөөлж, улмаар банкны системд хүндрэл учруулаа.

Сүүлийн 10 жилийн хугацаанд банкны системийн нийт актив 20 дахин өсч 3.65 их наяд төгрөг (2.9 тэрбум ам.доллар)-т хүрсэн ч тайлант онд өсөлтийн хурд саарав.

Төв банкнаас Анод банкиг хяналтандаа авсныг эс тооцвол банкны систем энэхүү хүндрэлтэй үеийг даван гарч чадлаа.

Бусад улс орнуудын жишгээр төрөөс банкин дахь иргэд байгууллагын харилцах, хадгаламжид баталгаа гаргасан нь дотоодын банкны системийн найдвартай байдлыг улам бэхжүүлэв.

Өнгөрсөн онд ихээхэн бэрхшээлтэй асуудлууд тулгарч байсан хэдий ч Голомт Банкны хувьд эдийн засгийн шинэ нөхцөл байдалд анхаарал тавин ажилласнаар, төлөвлөгөөт зорилтуудаа хэрэгжүүлж, урьдын адил санхүүгийн болон үйл ажиллагааны ололт амжилт дүүрэн жил байлаа.

Бизнесийн амжилтуудаасаа дурьдвал, өнгөрсөн онд бид 7 шинэ салбарыг нийслэл Улаанбаатарт, 6 шинэ салбарыг хөдөө орон нутагт буюу Дорноговь, Орхон, Дархан-Уул аймагт, ялангуяа Монгол улсын баруун хязгаар Ховд, Баян-Өлгий аймагт өөрийн салбар сүлжээгээ нээсэн нь хамгийн тэмдэглүүштэй зүйл болмоо. Ингэснээр оны эцэст салбар тооцооны төв 53-т

хүрч, үүнээс 33 нь нийслэл Улаанбаатарт, 20 нь аймгийн төвүүдэд ажиллаж байна. Эдгээр салбар нь 24 цаг, 7 хоног, 365 хоногийн зарчмаар тасралтгүй ажиллах дуудлага хүлээн авах төв, интернэт болон телефон банкны үйлчилгээнд бүрэн холбогдсон билээ.

Түүнчлэн бид Улаанбаатар хотын төдийгүй хөдөө орон нутгийн иргэдэд зориулсан Автомат Теллерийн Машины сүлжээг өргөжүүлэхэд анхаарлаа хандуулж, хөдөө орон нутагт байрлах Автомат машины тоог нэмэгдүүлээ.

Монгол Улсад төлбөрийн картын системийг анхлан нэвтрүүлсний 10 жилийн ойд зориулж төлбөрийн картын аюулгүй байдлын номер нэг стандартад нийцсэн EMV чип картыг Монгол Улсад анх удаа нэвтрүүлж, эрхэм харилцагчиддаа хамгийн найдвартай төлбөрийн картын үйлчилгээг санал болгосны зэрэгцээ, PayPass карт гаргаснаар хамгийн сүүлийн үеийн нэг цэгийн борлуулалтын технологийг нэвтрүүлэхэд анхдагч болов. Бид Монгол Улсад анх удаа “Бээжин 2008” Олимпын Наадмын бэлгэдэл бүхий Виза карт, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтарсан ко-бренд картыг тус тус нэвтрүүлээ.

Мөн манай банк дэлхийд нэр хүнд бүхий Американ Экспресс байгууллагын Монгол Улсад үйлчилгээ үзүүлэх онцгой эрхт албан ёсны банкаар, Олон Улсын Агаарын Тээврийн Холбооны Монгол Улс дахь төлбөр тооцоо гүйцэтгэгч банкаар сонгогдлоо.

Хэрэглээний үнийн индексийн 40 хүртэлх хувийг хүнсний бараа бүтээгдэхүүн эзэлж байна. Банк нь Хүнс Хөдөө Аж Ахуйн Яамтай хамтран гадаадаас импортолдог бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөг багасгах, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээ дотоодоосоо хангах суурь нөхцөлийг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн үр ашгийг нэмэгдүүлж, хүнсний бүтээгдэхүүний чанарын стандартыг сайжруулах зорилго бүхий төслийг санхүүжүүлэх хөдөө аж ахуйн зээлийн хөтөлбөрийг эхлүүлээ.

Үнэт цаасны зах зээлийг дэмжихэд чухал алхам болгож Монголын Орон Сууцны Санхүүжилтийн Корпорацитай хамтран Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй анхны ипотекеэр баталгаажсан 1 тэрбум төгрөгийн бондыг гаргалаа. Энэхүү орон сууцны зээлийн багц нь урьдчилгаа төлбөр өндөр, зээлийн эргэн төлөлтийг орлоготой нь уялдуулсан, зээлийн төлбөрийн орлогод эзлэх харьцаа нь бага байдаг зэргээрээ бусад улс орны орон сууцны зах зээлд үүсээд буй хүндрэлтэй байдлаас эрс ялгаатай юм.

Мөн бид харилцагчиддаа ямар ч цаг үед үнэ цэнээ баталгаатай хадгалах алтны хадгаламжийн үйлчилгээг шинээр нэвтрүүлснээс гадна мобайл банкны үйлчилгээгээр үйл ажиллагаагаа өргөжүүллээ.

Байгууллагын банкны бизнесийн бодит өсөлт, хөгжилтийг дэмжиж Төслийн Санхүүжилтийн болон Уул уурхайн хэлтсийг шинээр байгуулав.

Тайлант жилийн эхээр бид орчин үеийн техник технологи бүхий сургалтын төвийг нээж, бүрэн ашиглалттай ажиллуулж байна. Тайлант оны хоёрдугаар хагаст Мэдээллийн Технологийн хэлтэс, Бүртгэл Тооцооны газрын ажилтнууд Байгууллагын Банкны газар, Иргэдийн банкны газрын ажилтнуудын дэмжлэгтэйгээр Грэйп Банк системд суурилсан банкны бүртгэлийн шинэ системийг нэвтрүүлэх ажлыг уйгагүй хичээл зүтгэл гаргаж хийсний үр дүнд шинэ оны эхээр уг системийг амжилттай хэрэгжүүлж эхэллээ.

Мөн Компанийн зохистой удирдлагын бодлого, Байгууллагын ёс зүйн дүрмийг нэвтрүүлэхийн сацуу Мөнгө угаахтай тэмцэх, Банкны аюулгүй байдлыг хангах журмуудыг сайжруулснаар Компанийн зохистой удирдлагыг боловсронгуй болгож шинэ шатанд гаргалаа.

Тайлант онд санхүүгийн тайлан тэнцлийн бүтцэд оновчтой өөрчлөлт оруулсны дүнд татварын дараах ашгийг 65 хувиар нэмэгдүүлж, санхүүгийн гүйцэтгэлийн хувьд онцлог жил байлаа.

Банк ашигт ажиллагааны үзүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор тайлант оны эхний саруудад харилцах, хадгаламжийн хүүг шат дараатай бууруулсан боловч эх үүсвэрийн өсөлт эрс саарсан болно. Гэсэн хэдий ч хадгаламжийн хэмжээг өмнөх оны түвшинд хадгалж, 2006 оны түвшингөөс 284 тэрбумаар буюу 80 хувиар өсгөсөн юм.

Нөгөө талаас манай банкны зээлийн багцын хэмжээ оны эцэст 39 хувиар өсч, 448 тэрбум төгрөгт хүрсэн хэдий ч зээл хадгаламжийн харьцаа системийн дундаж үзүүлэлт болох 113 хувиас харьцангуй доогуур буюу 89 хувь байгаа нь манай үр ашгийн чадавхид бодитой сайжралт гарсныг харуулж байна. Түүнчлэн зээлийн бодлого, стандарт, шалгуурыг өндөрсгөж ажилласны дүнд чанаргүй зээлийг 4.2 хувиас 3.9 хувь болгон бууруулсан амжилт гаргав.

Дээр дурьдсан бодлого, үйл ажиллагааны үр дүнд банкны нийт актив 7 хувиар өсч 697 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь 2 жилийн өмнөх үзүүлэлтээс 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Тайлант онд банкны орлогын төлөв байдал олон улсын тэргүүлэгч банкуудаас эрс ялгаатай байсан ба банкны цэвэр хүүгийн орлого 2007 онд 14.3 тэрбум төгрөг байсан бөгөөд 80 хувиар өсч 25.7 тэрбум төгрөгт хүрсэн өндөр үр ашиг бүхий жил байлаа. Үүнтэй адил хүүгийн бус орлого нь мэдэгдэхүйцээр буюу 23.2 хувиар өсч 8.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Салбар нэгжүүдээ өргөжүүлэн бизнесээ эрчимтэй

Гүйцэтгэх Захирлын мэндчилгээ (үргэлжлэл)

хөгжүүлж, шинээр банкны бүртгэлийн систем нэвтрүүлсэн зэрэгтэй холбоотойгоор үйл ажиллагааны зардал 5.1 тэрбум төгрөгөөр өсч 15.2 тэрбум төгрөгт хүрлээ. Уг өсөлтийн гуравны нэг хувь нь ажиллах хүчний зардлын өсөлт гэдгийг дурьдах нь зүйтэй. Хэдийгээр үйл ажиллагааны зардал өссөн ч нэг ажилтанд ногдох ашгийн хэмжээ 10.1 сая төгрөгөөс 14 сая төгрөг болж 39 хувиар өсөхийн зэрэгцээ, зардал орлогын харьцаа 2007 онд 46.7 хувь байсан бол 2008 онд 43.8 хувь болж үр ашгийн үзүүлэлт сайжирсан билээ.

Эдийн засгийн эргэлт удааширсан нь манай эзэлдэгчдийн бизнесийн өсөлтөд дарамт учруулж, улмаар эзэлийн эрсдэлийн сангийн зардал 1.7 тэрбум төгрөгөөс бараг 4 тэрбум төгрөгт хүрч байгаад онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш тасралтгүй амжилттай ажилласан арван дөрөв дэх жилд үйл ажиллагааны татварын өмнөх ашиг 2007 онд хүрсэн 9.2 тэрбум төгрөгийн амжилтаас 69 хувиар буюу 6.3 тэрбумаар өсч, нийт 15.5 тэрбум болж өслөө. Улсад 3.3 тэрбум төгрөгийн орлогын албан татвар буюу урьд жилээс 2 дахин өссөн дүнгээр татвар төлсний дараа, татварын дараах ашиг өмнөх жилээс 65 хувиар өсч буюу 12.2 тэрбум төгрөг боллоо. Энэ нь олон саад бэрхшээлүүдтэй байсан жилийн хувьд томоохон амжилт юм.

Үйл ажиллагааны ололт амжилтуудаасаа дурьдвал банкны Тэргүүн дэд захирал Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Хөдөлмөрийн Гавъяаны улаан тугийн одонгоор шагнуулсан баярт үйл явдалтай зэрэгцэн, Ерөнхийлөгчийн нэрэмжит Үндэсний Бүтээмжийн Шагналыг дахин хүртэн (уг нэр хүндтэй шагналыг авсан цорын ганц банк гэдэг нэр төрөө хэвээр хадгалж) хүндэтгэлийг хүлээж, түүгээр зогсохгүй Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын “Шилдэг компанийн нийгмийн хариуцлагатай байгууллага” шагналын анхны эзнээр тодорлоо. Тайлант онд банк нь банк хоорондын гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээн болон бусад төрлийн тэмцээн уралдаануудад амжилттай оролцож эхний байруудыг эзэлснээр спортын хувьд амжилт бүтээлээр дүүрэн дахин нэг жилийг ардаа орхилоо.

Тайлант онд олон төрлийн ивээн тэтгэлэг, хандивын хөтөлбөрөөр дамжуулан урт хугацаанд байнга эрхэмлэж ирсэн шилдэг нийгмийн хариуцлагатай байгууллага байх зорилгоо амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд манай банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Баясгалангаар ахлуулсан Монгол Улсын баг тамирчид “Бээжин 2008” Олимпийн Наадмаас түүхэндээ байгаагүй амжилт гаргаж, хос алт, хос мөнгөн медальтайгаар эх орондоо эргэж ирсэнд Монголын Үндэсний Олимпийн Хорооны албан ёсны түнш, ерөнхий ивээн тэтгэгч

болох манай банкны хувь нэмэр багагүй байсныг бахархалтайгаар тэмдэглэх нь зүйтэй.

Долоон жил дараалан зохион байгуулж буй их дээд сургуулиудын төгсөх ангийн шилдэг оюутнууд оролцдог Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг Монголбанктай хамтран амжилттай зохион байгууллаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга маань 2009 оныг 2008 онд тохиосон сөрөг өөрчлөлтүүд газар авч, санхүүгийн систем болон эдийн засгийн хувьд ихээхэн хүндрэл бэрхшээлтэй жил болно гэдгийг дээр дурьдсан билээ. Иймд олон улсын зах зээл дээр бодитой зерэг өөрчлөлтүүд гарч, тогтворжих хүртэл Голомт Банк өөрийн бизнесийн үйл ажиллагааныхаа хэсэг бүрт онцгой анхаарал хандуулж хамгийн зөв зохистой арга хэмжээ авч, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд шуурхай зохицон, бэрхшээлийг амжилттайгаар даван туулах болно.

Дэлхий даяар даамжран үргэлжилсээр буй эдийн засгийн хямралын нөлөөг бууруулахын тулд өөрийн орны болон бүс нутгийн эдийн засгийн үйл явцыг анхааралтай ажиглахын зэрэгцээ, одоо байгаа болон ирээдүйд бий болох бизнесээ амжилттай удирдах хамгийн зөв зохистой арга хэрэгслүүдийг авч хэрэгжүүлэх болно. Энэхүү арга хэрэгслүүд нь Монголчуудын өмчлөх эрх, хүчирхэг капитал, өндөр хөрвөх чадвар, тов тодорхой стратеги, байгууллагын ухаалаг соёл, тогтвортой удирдлагын баг, бизнесийн шийдэмгий франчайз зэрэг бидний анхаарлаа хандуулж, өв уламжлал болгосон зүйлс төдийгүй үйлчилгээний бүхий л салбар нэгжүүдээс харилцагчиддаа хамгийн өндөр үр ашигтай, хамгийн бага зардалтай банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээг санал болгохыг хичээж ирсэн зүтгэлд суурилах болно.

Хэдийгээр ирж буй жил даван туулахад бэрхшээлтэй их сорилтыг дагуулж байгаа хэдий ч дэлхий дахин ужиг дефляцийн эсрэг тэмцэж буйн нэгэн адилаар манай банкны 874 ажилтан, албан хаагчид онцгой хичээл зүтгэл гарган ажиллаж, хүндрэл бэрхшээлийг даван туулахын зэрэгцээ Голомт банк нь Монголын бүх банкууд дундаас хамгийн хүчтэй, үлгэр жишээ банк байсаар байна гэдгийг баталгаажуулах болно.



Жон П. Финиган

Гүйцэтгэх захирал


Эдийн засгийн ТОЙМ




Монгол Улсын ДНБ 2008 оны эцэст өмнөх оны эцэстэй харьцуулахад 8.9 хувиар өсч, 6.1 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэхүү өсөлтийг хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл болон үйлчилгээний салбаруудын өсөлт голлон бүрдүүлжээ. Ийнхүү 2008 он экспортын тааламжтай нөхцөл, цаг агаарын таатай байдлаар дэмжигдэн бодит эдийн засаг 7-оос дээш хувиар дараалан өссөн 5 дахь жил боллоо.

Монгол Улсын ДНБ-ий өсөлт 2004 онд зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990 оноос хойш хамгийн өндөр хувиар өсч, 10.8 хувьд хүрсэн бөгөөд үүнээс хойш жилд дунджаар 9 хувиар өсчээ. Мөн түүнчлэн, нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 2004 онд 707 ам.доллар байсан бол 2008 онд 2.6 дахин өсч 1,819 ам.долларт хүрчээ.

ДНБ-ий бодит өсөлт (%)



Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ (ам.доллар)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

*-урьдчилсан гүйцэтгэл

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар ДНБ-ий өсөлтөд голлох үүрэг гүйцэтгэж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг шингээдэг эдийн засгийн гол салбар болсон хэдий ч 2008 онд уг салбарын нэмүү өртөг дөнгөж 0.1 хувиар өсч, ДНБ-ий өсөлт дэх уул уурхайн салбарын оролцоо 1.6 хувьд хүрэв. Малын тоо толгой болон газар тариалангийн бүтээгдэхүүний өсөлтийн үр дүнд хөдөө аж ахуйн салбар ДНБ-ий өсөлтийн 1.9 хувийг бүрдүүлээ. Малын тоо 3 сая толгойгоор буюу 7.5 хувиар өсч, 43.3 сая толгойд хүрсэн бол газар тариалангийн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 21 хувиар өсчээ. Тайлант онд үйлчилгээний салбар ДНБ-ий өсөлтөд гол хувь нэмэр оруулагч байр сууриа хэвээр хадгалж ДНБ-ий нийт өсөлтийн 3.4 хувийг бүрдүүлсэн ба уг салбарын нэмүү өртөг өмнөх оныхоос 15.9 хувиар өссөн байна.

ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо

	ДНБ	ХАА	Уул уурхай	Үйлчилгээ	Бусад
2004	10.8%	2.2%	1.3%	5.7%	1.6%
2005	7.1%	1.5%	0.9%	3.8%	0.9%
2006	8.6%	1.9%	1.8%	3.0%	1.9%
2007	10.2%	2.3%	2.0%	3.7%	2.2%
2008*	8.9%	1.9%	1.6%	3.4%	2.0%


Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

*-урьдчилсан гүйцэтгэл


УЛСЫН ТӨСӨВ

Улсын төсөв 2008 онд 305.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн алдагдал ДНБ-ий 5 хувьтай тэнцэв. Нийт орлого, тусламжийн дүн өнгөрөгч оноос 14.7 хувиар өссөнд нэмэгдсэн өртгийн албан татвар, гадаад худалдааны татвар болон онцгой татварын орлогын дүнд гарсан томоохон өсөлтүүд нөлөөлжээ. 2008 онд Засгийн Газрын нийт орлогын 87.6 хувийг татварын орлого бүрдүүлсэн байна. Нийт зардал, цэвэр зээллэгийн дүн 40.9 хувиар өссөн ба энэхүү өсөлтийг цалин, хөрөнгө оруулалтын зардлын өсөлт голлон бүрдүүлжээ.

Улсын төсвийн тэнцэл (сая ам.доллар)



Улсын төсвийн тэнцэл/ДНБ (%)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо
*-урьдчилсан гүйцэтгэл


ГАДААД ХУДАЛДАА

Тайлант онд нийт импортын хэмжээ 3,615.8 сая ам.доллар, экспортын хэмжээ 2,539.3 сая ам.долларт хүрснээр гадаад худалдааны тэнцэл 1,076.5 сая ам.долларын алдагдалтай гарав. Оны эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт эргэлтийг 2007 оны эцэстэй харьцуулахад 49.4 хувиар (2,035.8 сая ам.доллар) өсч 6,155.1 сая ам.долларт хүрсэн бол гадаад худалдааны алдагдал өмнөх оны мөн үед 220.9 сая ам.доллар байснаас 3.9 дахин өсч 1,076.5 сая ам.долларт хүрэв.

Гадаад худалдааны нийт эргэлт (сая ам.доллар)



Гадаад худалдааны тэнцэл/ДНБ (%)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

БНХАУ өсөн жил дараалан Монгол Улсын гадаад худалдааны хамгийн том түнш хэвээр байгаа ба хоёр орны хоорондын хоёр талт худалдааны нийт дүн Монгол Улсын нийт гадаад худалдааны 46.1 хувийг эзэлж байна. 2008 онд хоёр орны хоорондын нийт худалдааны дүн 2,837.7 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 35.9 хувиар өссөн ба үүний 1,643.7 сая ам.доллар нь экспорт, 1,194.0 сая ам.доллар нь импорт байна.

2007 онтой харьцуулахад нийт экспорт 30.3 хувь(590.1 сая ам.доллар)-аар өссөний 35.2 хувь (207.5 сая ам.доллар) нь үнийн өсөлтөөс бий болжээ. Оны эхний хагаст зэсийн баяжмалын үнэ болон тоо хэмжээ аль аль нь өссөн бол оны сүүлийн хагаст тоо хэмжээ 4.1 хувь(24.9 мянган тонн)-аар буурч, мөнгөн дүн нь 3.0 хувь(24.2 сая ам.доллар)-аар өссөн байна. 2008 онд нэг тонн зэсийн баяжмалын дундаж үнэ 1,433.6 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсчээ.

Экспортын өсөлт (нэрлэсэн)

	Нийт экспорт	Зэсийн баяжмал	Алт	Нүүрс	Цайрын баяжмал	Түүхий нефть	Бусад
2004	41.2%	13.5%	11.5%	0.0%	0.0%	0.3%	15.9%
2005	22.4%	7.0%	6.9%	0.3%	0.5%	1.1%	6.6%
2006	44.9%	18.5%	7.9%	1.3%	2.7%	0.6%	13.9%
2007	26.3%	11.0%	3.2%	1.6%	2.4%	0.7%	7.4%
2008	30.3%	10.0%	7.2%	2.2%	1.8%	1.2%	7.9%

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Нийт импорт 3,615.8 сая ам.долларт хүрч, 66.6 хувь (1,445.7 сая ам.доллар)-аар өссөний 64.2 хувь (928.8 сая ам.доллар) нь үнийн өсөлт, 35.8 хувь (516.9 сая ам.доллар) нь тоо хэмжээний өсөлт байв. Импортын өсөлтөд шатахуун, машин тоног төхөөрөмж, барилгын материалын импортын өсөлт голлон нөлөөлсөн бөгөөд 2008 онд эдгээр бүтээгдэхүүнүүдийн импортын нийт импортод эзлэх хувийн жин харгалзан 27.8, 29.4, 19.0 хувь байв.

2008 онд Монгол Улсын импортын гол түнш орнууд болох ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ –ын импорт нийт импортын 34.4, 33.0, 6.6, 5.4, 4.3 хувийг тус тус эзэлж байв.

Импортын өсөлт (нэрлэсэн)


	Нийт импорт	Шатахуун	Машин, Тоног төхөөрөмж	Цаас, цаасан бүтээгдэхүүн	Тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги	Төмөрлөг	Бусад
2004	27.5%	6.4%	5.4%	0.5%	2.8%	1.9%	10.5%
2005	16.0%	4.4%	3.5%	0.4%	1.6%	1.2%	4.9%
2006	25.4%	7.7%	4.6%	1.3%	2.6%	1.7%	7.5%
2007	46.1%	12.8%	9.0%	3.1%	4.7%	3.5%	13.0%
2008	66.6%	17.8%	11.2%	7.7%	8.4%	4.9%	16.6%

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


МӨНГӨНИЙ БОДЛОГО

Өсөн нэмэгдсээр байгаа инфляцийг бууруулах зорилгоор Төв банкны зүгээс жилийн турш мөнгөний нийлүүлэлтийг хумих бодлого баримталсан ба үүний дүнд 2008 оны эцэст мөнгөний нийлүүлэлт (M2) өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувь (59.9 тэрбум төгрөг)-аар буурч ДНБ-ий 38.2 хувьтай тэнцэж, 2.3 их наяд төгрөг (1.8 тэрбум ам.доллар) боллоо.

Нийт мөнгө (M2), нийт мөнгөний өсөлт (%)



Нийт мөнгө (M2) /ДНБ (%)




Эдийн засгийн тойм (үргэлжлэл)

Хэдийгээр мөнгөний бодлогын гол зорилго нь инфляцийг тодорхой хязгаарт барих замаар үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хадгалах боловч инфляци оны турш тасралтгүй өсч, 2008 оны 8 дугаар сард 34.2 хувьд хүрсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр түвшин байлаа. Жилийн эцэст инфляци харьцангуй буурч 22.1 хувьд хүрсэн ба үүнд хүнсний бүтээгдэхүүний үнэ (24 хувь), байр, ус, цахилгаан, шатахууны үнэ (22.6 хувь), тээврийн үйлчилгээний үнэ (25.8 хувь), гутал, хувцасны үнэ (16.5 хувь), боловсролын үйлчилгээний үнэ (39.9 хувь)-ийн өсөлтүүд голлон нөлөөлжээ.


2008 оны энэхүү өндөр инфляцийн түвшин нь чөлөөт эдийн засгийн орчинд гадаад худалдаанаас асар ихээр хараат байдалд байдаг Монгол Улс шиг орнуудад зайлшгүй нөлөөлөх импортын инфляцийн тусгал байв. Нийт инфляцийн 70 хүртэл хувь нь Хятадын юань, Оросын рублийн чангаралт (рублийн хувьд 8 дугаар сарын сүүлч хүртэл) болон эрчим хүч, үр тариа гэх мэт хүнсний бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт зэрэг гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан байна.

Эхэн үедээ уян хатан бус байсан мөнгөний бодлого нь эрсдэл даах чадварыг сулруулж, улмаар 2007 онд хамгийн өндөр түвшиндээ хүрсэн гадаад валютын нөөцийг бууруулсан бөгөөд гадаад валютын нөөцийн энэхүү бууралт нь 2000 оноос хойш 10 жилийн туршид харьцангуй тогтвортой байсан төгрөгийн ханшийг огцом унагав. Оны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш 1,267.51 төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 хувиар суларсан үзүүлэлт байв.

Инфляци (%)



Валютын ханш: USD/MNT




2008 оны эцэст, Монгол Улсын гадаад валютын нөөц 2007 онтой харьцуулахад 34.5 хувь буюу 335 сая ам.доллараар өсч, 637 сая ам.доллар болсон нь импортын 9.2 долоо хоногийн нөөцтэй тэнцүү байна.


БАНК, САНХҮҮГИЙН СИСТЕМ

Анод банкинд Төв банкнаас бүрэн эрхт төлөөлөгч томилсныг эс тооцвол банкны систем үндсэндээ эрүүл хэвээр байгаа бөгөөд системийн ашигт ажиллагааны түвшин хангалттай өндөр, зээлийн багц дахь чанаргүй зээлийн хэмжээ бага байна. Арван нэгдүгээр сард Засгийн Газраас банкны систем дэх иргэдийн хадгаламжид баталгаа гаргаж, улмаар шинэ оны эхэнд харилцах дансыг хамаарах болгож өргөжүүлсэн нь системийг улам бүр баталгаажуулав.

Нийт зээл - Банкны систем (сая ам.доллар)



Чанаргүй зээлийн хувь - Банкны систем (%)




Дотоодын эх үүсвэрийн өсөлт зогсонги байдалд орсон, системийн зээл хадгаламжийн харьцаа 113 хувьд хүрсэн өнөөгийн нөхцөлд хөрвөх чадвар хамгийн анхаарал татсан асуудал болж байна. Эдийн засгийг урамшуулах, импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон дотоодын хэрэгцээг дэмжих зорилгоор Засгийн Газраас банкны системд нэмэлт эх үүсвэр олгож байгаа ба энэхүү хөрөнгө нь барилгын салбарт шаардагдах нэмэлт санхүүжилтийг хангах, уг салбарт олгогдох банкны зээлийг тасалдуулахгүй байхад зориулагдаж байна. Эдгээр арга хэмжээнүүд нь Сингапур гэх мэт бусад орнуудын Засгийн Газраас санхүүгийн системийн өсөлтийг хангахаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдтэй төстэй юм.


Банкны системийн үзүүлэлтүүд	2004	2005	2006	2007	2008
Банкны тоо	17	17	16	16	16
Банкны салбаруудын тоо	682	731	832	981	1 080
Банкны 1 салбарт ноогдох хүн ам	3 703	3 501	3 132	2 686	2 485
Нийт актив (сая ам.доллар)	917	1 298	1 992	2 892	2 880
1 хүнд ноогдох хадгаламж ('000 төгрөг)	204	270	374	575	566
Нийт актив, ДНБ-ий харьцаа	59.5%	70.0%	62.5%	73.6%	59.5%
Нийт зээл, ДНБ-ий харьцаа	33.5%	36.8%	32.9%	47.3%	44.3%
Өөрийн хөрөнгө, ДНБ-ий харьцаа	9.3%	9.1%	7.9%	8.2%	5.6%
Чанаргүй зээлийн хувь (%)	6.4%	5.6%	4.9%	3.3%	7.1%
Дундаж өөрийн хөрөнгийн хүрэлцээ	20.0%	18.2%	18.1%	14.2%	11.4%
Банкны систем дэх улсын оролцоо	6.0%	4.9%	-	-	-
Банк бус санхүүгийн байгууллагын тоо	114	150	163	137	132

2008 оны турш Монголын хөрөнгийн биржэд 5.3 тэрбум төгрөг(4.2 сая ам.доллар)-ийн үнэлгээ бүхий 7 компани шинээр бүртгэгдэж, хувьцаагаа амжилттай арилжаалав. Нийт 62.4 тэрбум төгрөг (49.2 сая ам.доллар)-ийн арилжаа хийгдэж, оны эцэст нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 515.9 тэрбум төгрөг (470 сая ам.доллар) байсан нь 2007 онтой харьцуулахад харгалзан 39 хувь болон 28 хувиар тус тус буурсан байна.

Монголын хөрөнгийн бирж –
Зах зээлийн нийт үнэлгээ (сая ам.доллар)



Монголын хөрөнгийн бирж –
Үнэт цаасны гүйлгээний нийт дүн (сая ам.доллар)



Байгууллагын ХӨГЖИЛ


ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО


Хэтийн зорилго

Монголын банкны салбарт тэргүүлэгч, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаатай, нэр хүнд бүхий найдвартай банк байна.

Эрхэм зорилго

Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг, өндөр үр ашиг бүхий хөгжих чадвартай, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байна.






КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Голомт банк “Компанийн зохистой засаглал”-ын хэм хэмжээ болон олон улсад шалгарсан туршлагыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг эрмэлздэг бөгөөд энэ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкнаас гаргасан журмуудыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийн зэрэгцээ дотооддоо дүрэм журам боловсруулан хэрэгжүүлж байна.

Бид “Компанийн засаглал”-ын хэм хэмжээг мөрдөн хэрэгжүүлэхдээ хувь нийлүүлэгчдийн нягт харилцаа, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Аудитын Хорооны үр ашигтай хамтын ажиллагаа, үйл ажиллагааны үр дүнд тулгуурласан урамшуулал, нээлттэй ил тод байдал гэсэн үндсэн 4 зарчмыг баримталдаг.

Банкны эргэх холбоог сайжруулах зорилгоор ажилтан албан хаагчид болон харилцагчдаас ирсэн саналыг хүлээн авч, үр дүнг нь удирдлагын баг хянан хэлэлцэж үнэ цэнэ бүхий зөвлөмжийг үнэлэн урамшуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өнгөрөгч онд Банк нь Ерөнхийлөгчийн нэрэмжит Үндэсний Бүтээмжийн шагнал (энэхүү нэр хүндтэй шагналыг хүртсэн цорын ганц банк гэсэн байр сууриа хадгалмаа) болон “Шилдэг компанийн нийгмийн хариуцлагатай байгууллага” гэсэн нэр хүндтэй шагналуудыг хүртсэний зэрэгцээ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зохион явуулсан “Интерпренер 2008” ёслолын ажиллагаанаас “Сайн засаглалыг хэрэгжүүлэгч-Оны шилдэг байгууллага”-аар шалгарсан юм. Энэ нь бидний үйл ажиллагаагаа ил тод нээлттэй тогтмол тайлагнадаг байдал, ажилтнууд болон хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын ахиц дэвшил, нийгмийн хариуцлагатай байдлыг үнэлсэн шагнал юм.



УДИРДЛАГЫН БАГ



Г. Ганболд

Үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн
Дэд захирал



Г. Ганхуяг

Дэд захирал, Хөрөнгийн Удирдлагын
Газрын захирал



М. Чимэгмөнх

Дэд захирал, Санхүүгийн Удирдлагын
Газрын захирал



Н. Нацагдорж

Дэд захирал, Иргэдийн Банкны
Газрын захирал



Л. Оюун-Эрдэнэ

Дэд захирал, Байгууллагын Банкны
Газрын захирал



М. Чингүн

Дэд захирал, Эрсдэлийн Удирдлагын
Газрын захирал



Ж. Ганбат

Дотоод Аудитын Газрын захирал

Байгууллагын хөгжил (үргэлжлэл)

Хувь нийлүүлэгчид

Голомт банк нь “Бодь интернэшнл” ХХК гэсэн нэг хувь нийлүүлэгчтэй Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөл


Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувь нийлүүлэгчдээс томилогдсон банк санхүү, бизнесийн салбарт олон жил ажилласан туршлага бүхий гурван хүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөл нь Банкны төсөв, бизнесийн болон хэтийн төлөвлөгөөг батлах, удирдлагуудыг томилох, хөндлөнгийн хяналт тавих, банкны бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох зэрэгт удирдлагаар хангаж, эрсдэлд үнэлгээ өгөх замаар банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

Аудитын хороо

Аудитын хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон банкны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнана. Дотоод Аудитын Газартай өдөр тутмын харилцаатай байна.

Удирдлагын баг

Голомт Банк санхүүгийн системд туршлага бүхий чадварлаг удирдлагын багтай бөгөөд тэдний зарим нь банк байгуулагдах цагаас эхлэн өнөөг хүртэл ажиллаж байна. Бүтэц зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирал, Дэд захирал, Газрын захирал, Хэлтсийн захирал гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



ХҮНИЙ НӨӨЦ

Банкны ололт амжилтын гол үндэс нь чадвартай, ажиллах эрч хүч урам зоригтой, бүтээмж өндөртэй ажилтнууд байдаг билээ. 2008 оны эцэст банкны ажилтнуудын тоо өмнөх оноос 20 хувиар өсч 874-т хүрлээ. Нийт ажилтнуудын 60 хувь нь банкны үйлчилгээг харилцагч үйлчлүүлэгчдэд хүргэдэг 53 салбар тооцооны төвд, 40 хувь нь төв албанд ажиллаж байна.

Хүний нөөцийн үзүүлэлтүүд

	2007	2008
Ажилтны тоо	728	874
Салбар, тооцооны төвүүд	57%	60%
Төв	43%	40%
Хүйсийн харьцаа (Эрэгтэй/Эмэгтэй)	29-71	30-70
Салбар, тооцооны төвүүд	25-75	24-76
Төв	41-59	39-61
Дунд түвшний удирдлага	40-60	45-55
Дээд түвшний удирдлага	50-50	50-50
Мэргэжлийн зэрэг		
Дээд боловсролтой	88%	88%
Дунд боловсролтой	12%	12%
Нас		
25 хүртэл	33%	34%
25-34	51%	50%
35-44	12%	12%
45-54	3%	3%
54-өөс дээш	1%	1%

Банк нь ажиллах хүчнийхээ тоо хэмжээг өргөжүүлэхэд бус, хамт олны эгнээнд шинээр элсэн орсон болон он удаан жил ажиллаж буй нийт ажиллагсдынхаа мэдлэг, хөдөлмөрийн бүтээмж, мэргэжлийн ур чадвар, үйлчилгээ үзүүлэх чадварыг сайжруулахад чиглэсэн тасралтгүй үргэлжлэх олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд илүүтэй ач холбогдол өгч, анхаарал тавьж байна. Үүнтэй ижил түвшний чухал зүйлийн нэг нь ажилдаа дур сонирхолтой, сэтгэл хангалуун ажилтнуудаа хэвээр хадгалах бөгөөд жилийн туршид бий болгосон амжилт, үр ашиг, үйл ажиллагааны бүтээмжийн өсөлт дээр тулгуурлан Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ажилтнуудын цалингийн ерөнхий түвшинг өсгөхөөр шийдвэрлэсэн.

Бүтээмжийг тууштай сайжруулах хөтөлбөрийн үндсэн хэсэг болгон ажлын гүйцэтгэлийн үнэлгээний стандартыг сайжруулж, банкны үнэ цэнэ бүхий нэн чухал албан тушаалтны ур чадварыг эн тэргүүнд хөгжүүлж, дэвшүүлдэг карьер хөгжлийн үнэлгээний тогтолцоог бий болгосон. Бид үйл ажиллагааны тоон болон чанарын өсөлттэй шууд дүйцэхүйц урамшууллын системээр дамжуулан хамгийн үр бүтээлтэй ажилласан нэгж, ажилтнуудаа шагнаж урамшуулж, жил бүр банкны шилдэг ажилтнуудаа шалгаруулж өөрийн харилцагч банкууд, бусад мэргэжлийн хамтран ажиллагч байгууллагуудтай хамтран гадаадад сургалтанд хамрагдах боломжоор хангадаг удаан хугацааны уламжлалаа хадгалсаар байна.

Банкны үйлчилгээний чанарыг сайжруулахад хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг мэргэжлийн ажилтнуудын ур чадварыг сорьсон сонирхолтой уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулж, шилдгийн шилдэг ур чадвар бүхий ажилтнуудыг тодруулан шагнаж урамшуулахын зэрэгцээ тэдэнд тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу өөрийн ур чадвараа бусад ажилтнуудтайгаа хуваалцах, бусаддаа зааж өгөх боломжийг олголоо.

Түүнчлэн, харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулж, өдөр тутмын үйл ажиллагаан дахь үйлчилгээний хурдыг нэмэгдүүлэх, хамгийн шилдэг харилцагчийн үйлчилгээтэй салбар, нэгжийг шалгаруулах зорилготой “Харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулах аян”-ыг 53 салбар, тооцооны төвүүдийн дунд амжилттай зохион байгуулаа.

Хүний нөөц (үргэлжлэл)

Тайлант онд манай 24 тэргүүний ажилтан Монголбанк болон Монголын Банкны Холбооноос банк санхүүгийн салбарын шилдэг ажилтанд олгодог нэр хүндтэй шагналуудыг хүртлээ. Мөн 3 ажилтан Биеийн тамир Спортын Улсын Хорооны Хүндэт тэмдэг, Спортын алдар тэмдгээр, 7 ажилтан Сангийн Яамны жуух бичгээр, 6 ажилтан Монголын Залуучуудын Холбооны шагналаар тус тус шагнагдлаа.

Сургалт, хөгжил

Голомт банк “Суралцагч байгууллага”-ынхаа хувьд ажилтнуудаа хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлд ихээхэн анхаарал тавьдаг. Энэ утгаараа банк нь 120 хүртэл хүн хүлээн авах хүчин чадалтай орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон сургалтын төвийг ашиглалтанд оруулаа. Өнгөрөгч 2008 онд Банк гадаад, дотоодын 150 орчим урт болон богино хугацааны сургалт зохион байгуулж, нийт 1,988 ажилтан хамрагдсан нь дунджаар нэг ажилтанд 29 цагийн сургалт, 2.42 сургалтын хөтөлбөр ногдож буй юм. Сургалтанд хамрагдагсдын тоог өмнөх онтой харьцуулахад ойролцоогоор 60 хувиар өссөн байна. Компанийн нийгмийн хариуцлагын нэгэн илрэл болгож боловсролын болон сайн дурын байгууллагуудад уг сургалтын төвөө түшиглэн төрөл бүрийн хурал зөвлөгөөн, сургалтуудыг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.

Банкнаас өөрийн ажилтнуудаа дэмжиж, ажилтнуудынхаа боловсролын зэргийг дээшлүүлэх зорилгоор Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, БНСУ-ын Хандоны Их сургуулийн хамтарсан магистрийн сургалтанд болон мэргэжлийн их дээд сургуулиудтай хамтран мэргэшсэн нягтлан бодогч бэлтгэх сургалтуудад ажилтнуудаа хамруулж, суралцах боломж нөхцөлийг нь бүрдүүлж ирлээ.

Сургалтын статистик

	2007	2008
Нэг ажилтанд ногдох сургалт, цагаар	23.5	28.9
Сургалтанд оролцогчид	1,236	1,988

ДЭД БҮТЭЦ

Тайлант онд Голомт банк мэдээллийн технологийг сайжруулан шинэчлэх, дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлээр цаг хугацаа, хүч хөдөлмөр ихээхэн шаардсан хэд хэдэн төслийг хэрэгжүүлж дуусгаснаар дотоодын банкны системд шинэ дэвшилтэт технологийг анхлан нэвтрүүлэгч гэсэн байр сууриа хадгалаа.

Банк нь төлбөрийн картан аюулгүй байдлын хамгийн сүүлийн үеийн стандартад нийцсэн EMV чип картыг Монгол Улсад анх удаа нэвтрүүлж, Монгол Улсын төлбөрийн картан аюулгүй байдлыг хангах, төлбөрийн картан гүйлгээнд гарч болзошгүй эрсдэлийг бууруулахад цоо шинэ ахиц дэвшил гаргалаа.

Монгол Улсын интернэт банкны үйлчилгээнд тэргүүлэгч банкны хувьд интернэт банкны системээ улам сайжруулж, харилцагчийн ашиглах үйлдлийн боломжийг нэмэгдүүлж, найдвартай байдлын түвшинг сайжруулснаар интернэт үйлчилгээний сувгийг илүү хурдтай, найдвартай, үр ашигтай болгож, харилцагчдад хүрэх үр ашгийг улам нэмэгдүүллээ.

Банк нь салбар, нэгжүүдийн харилцаа холбооны зардлыг бууруулах, хоорондын харилцааг үр ашигтай, түргэн шуурхай болгох зорилгоор IP-Phone системийг иж бүрнээр нь нэвтрүүллээ.


Американ Экспресс байгууллагын Монгол Улс дахь онцгой эрхт албан ёсны банк болсонтой холбоотойгоор төлбөрийн картан суурь систем болон АТМ, картаар үйлчлэгч байгууллагуудын программыг Американ Экспресс картыг хүлээн авахад зориулж шинэчлэн суурилууллаа.

Грепбанк банкны шинэ систем

Үйлчилгээний чанар, үр ашиг, өртөг зардлын үр ашигтай байдлыг дээшлүүлэх зорилгын хүрээнд банкны үндсэн системээ шинэчлэх ажлын бэлтгэлийг хангалаа. Удаан хугацааны судалгаа шинжилгээний үндсэн дээр Монгол Улсын программ хангамжийн зах зээлд манлайлагч “ГрэйпСити Монгол” компанийн “Грэйпбанк” системийг сонголоо. “ГрэйпСити Монгол” нь Oracle Partner Network-ийн Монгол Улс дахь цорын ганц албан ёсны гишүүн Oracle Database Products-ын Value-Added Reseller (Хөгжүүлэгч) компани юм. Мөн Microsoft-ийн итгэмжлэгдсэн түнш бөгөөд Microsoft Dynamics SL, Microsoft Dynamics CRM, Microsoft Dynamics NAV-ийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ FNS компанийн Value-Added Reseller (Хөгжүүлэгч), Regional Service Pr (бүсийн үйлчилгээ үзүүлэгч) нь юм. Оны эхэнд Грэйпбанк системийг амжилттай хэрэгжүүлэхэд төслийн багийнхан болон банкны бүхий л газар, хэлтсүүд хүчин чармайлт гарган ажиллалаа.

Грэйпбанк төслийг хэрэгжүүлснээр бид салбар нэгжээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх үйлчилгээнийхээ чанар, хурдыг сайжруулахын зэрэгцээ банкны үйл ажиллагааны бүхий л шатанд хяналтын систем, бүртгэл тооцоо, дотоод мэдээллийн уялдаа холбоо, тайлагналтын чадавхиа сайжруулах болно.

Мэдээллийн технологийн ерөнхий схем



Үйл ажиллагааны ТОЙМ


ИРГЭДЭД ХАНДСАН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Салбарын сүлжээний өргөжилт

Голомт банк нь хүн амын нягтрал болон эдийн засгийн төвлөрөл ихтэй бүс нутагт борлуулалтын салбар сүлжээгээ өргөжүүлэх стратегийг баримталдаг. Тайлант онд Голомт банк Улаанбаатар хотын эрчимтэй хөгжиж буй дүүргүүдэд салбар сүлжээгээ өргөжүүлэн тэлж, нийслэл дэх салбар сүлжээний тоогоо 33-т хүргэв. Мөн түүнчлэн Баян-Өлгий, Ховд, Дорноговь аймагт салбар, тооцооны төвүүдийг шинээр нээж, Орхон, Дархан-Уул аймгууд дахь салбар сүлжээгээ өргөжүүллээ. Ийнхүү өнгөрөгч онд салбар сүлжээний тоогоо 9-өөр нэмэгдүүлж, нийт 53 салбар, нэгжтэй боллоо.

Харилцагч үйлчлүүлэгчиддээ банкны иж бүрэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүссэн цагт нь буюу 24 цаг, 7 хоног, 365 хоног гэсэн зарчмаар түргэн шуурхай, үр ашигтай, өртөг зардал багатайгаар хүргэхийн тулд сүүлийн үеийн дэвшилтэт техник технологид суурилсан үйлчилгээний сувгийг өргөжүүллээ. Үүнд:

- Орон нутаг дахь Автомат теллерийн машины тоог нэмэгдүүлж, нийт тоог 30-д хүргэв;
- Төлбөрийн карт хооронд шилжүүлэг хийхэд шимтгэлгүй болголоо;
- Монгол Улсын үүрэн телефон холбооны зах зээлд тэргүүлэгч Мобиком корпорацитай хамтран гар утасны үйлчилгээнд суурилсан мобайл банкны үйлчилгээг нэвтрүүлэв;
- Интернет банкны үйлчилгээний үр ашиг, хамрах хүрээ, үйлчилгээний боломжийг нэмэгдүүлэн шинэчлэлт хийв.



Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

Инфляцийн түвшин өндөр буй өнөө үед манай банк өөрийн харилцах хадгаламжийн дансны үйлчилгээний хураамж шимтгэлийг бууруулж, харилцагчийн хэрэгцээг хангахын тулд хамгийн өрсөлдөх чадвар бүхий үйлчилгээг санал болгож байна. Хадгаламжийн нөхцөл боломжийг нэмэгдүүлэх үүднээс бид Алтны хадгаламжийн шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээ.

Зээлийн үйлчилгээ

2008 оны эцэст иргэдийн болон жижиг дунд бизнесийн зээл банкны нийт зээлийн багцын 38 хувийг бүрдүүлж байгаа ба үүний 63 хувийг жижиг дунд бизнесийн зээл, 14 хувийг хэрэглээний зээл, 23 хувийг орон сууцны зээл (хамгийн сайн чанарын зээлд тооцогддог ба урьдчилгаа төлбөр нь худалдан авах үнийн хамгийн багадаа 30 хувь байх гэсэн шаардлага тавьдаг) тус тус эзэлж байна. Тайлант онд жижиг дунд бизнесийн зээл 65 хувиар, хэрэглээний зээл 23 хувиар, орон сууцны зээл 76 хувиар тус тус өсчээ.


Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангагч гол салбар болох жижиг дунд бизнесийн салбарыг дэмжих зорилгын хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулж зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх, олон улсын картаар урамшуулах, гуйвуулгын шимтгэлээс чөлөөлөх гэх мэт урамшуулалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээ.

Баялгийг бүтээгч үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжихийн тулд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан, уян хатан нөхцөл бүхий урт хугацаат төслийн зээлүүдийг олгох чиглэлээр олон улсын байгууллагын санхүүжилттэй томоохон төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллалаа. Үүнд:

- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банкны санхүүжилттэй (JBIC-TSL) жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээлийн 1-р шатыг амжилттай дуусгаж нийт 5.3 тэрбум төгрөгийн зээлийг олгосон ба 1.9 тэрбум төгрөгийн зээл олгогдохоор хүлээгдэж байна. Тухайн төслийн зээлийг олгосон салбараар нь ангилбал 38 хувь нь хүнсний салбарын үйлдвэрлэлд, 16 хувь нь барилгын материал, хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, 16 хувь нь аялал жуулчлал хөдөө аж ахуйн салбарт, 30 хувь нь үйлчилгээ, хэвлэл, эрүүл мэндийн салбарт олгогдсон байна.
- Дэлхийн банкны харъяа байгууллага Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн санхүүжилттэй (PSDP-II) хувийн хэвшлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих төслийн зээлийн 2-р шатыг амжилттай эхлүүлээд байна.
- Монгол Улсын Засгийн Газар, Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрлэлийн Яамтай хамтран хэрэгжүүлсэн “АТРЫН III” аяны хүрээнд газар тариалан эрхлэгчдэд 29.4 тэрбум төгрөгийн зээл олголоо.
- Үйлдвэрлэл, худалдааны салбарын жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Үйлдвэр Худалдааны Яамнаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 5 тэрбум төгрөгийн зээл олгов.
- Нидерландын Засгийн Газрын санхүүжилттэй эрчим хүчний хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих “Ногоон зээлийн баталгааны сан” төслийн зээлийн хүрээнд 355.5 сая төгрөгийн зээл олгосон байна.
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын хөрөнгө оруулалт хөгжлийн сангийн зээлээр нийт 820 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хамтран шийдлээ.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн хямрал улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж тодорхойгүй байдал үүсгэн, эдийн засгийн орчин бизнес эрхлэхэд таагүй байгаа энэ үед, арилжааны банкууд зээлийн бодлого, зээл олгох шалгуураа чангатгах, эргэн төлөлтийн хугацааг сунгах болон барьцаа хөрөнгийн үнэлгээнд тавих шаардлагыг өндөрсгөх зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлж байна. Хэдийгээр санхүүгийн нөхцөл байдал бэрхшээлтэй, хүнд байгаа ч бид улс орны эдийн засаг дахь мөнгөний эргэлтийн хурдыг нэмэгдүүлэхэд банкны салбар голлох үүрэгтэй гэдэг байр сууриа хэвээр хадгалж байна.

Жижиг дунд бизнесийн зээл (тэрбум төгрөг)



Үйл ажиллагааны тойм (үргэлжлэл)

Иймээс, бид эрхэм харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зээлийн хэрэгсэл, бүтцийг бий болгохын тулд тэдэнтэй нягт хамтран ажиллахын зэрэгцээ эрсдэлийг аль болох багасгах, уналтын үед хамгийн оновчтой стратеги баримтлахад нь, туслах чиглэлээр шаардлагатай зөвлөгөөг өгч байна.

Хэрэглээний зээл


Хэдийгээр Монголбанк жилийн турш мөнгөний хумих бодлого хэрэгжүүлж, дотоодын банкны систем дэх зээлийн тэлэлт үндсэндээ зогссон боловч Голомт банк тууштай харилцаар ирсэн, итгэл хүлээсэн харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг хангах үүднээс хэрэглээний зээлийг зохих хэмжээнд олгож оны эцэст хэрэглээний зээлийн багцын хэмжээ 23 хувиар өсч, 25 тэрбум төгрөгт хүрлээ.

Шинэ бүтээн байгуулалтыг дэмжих, хүрээлэн буй байгаль орчны бохирдлыг багасгах, харилцагчдынхаа үеэс үед өвлөгдөх өмч хөрөнгө эзэмших боломжийг дэмжих зорилгоор 1000 орчим айлд орон сууцтай болоход дэмжлэг үзүүлсэн ба 2008 онд орон сууцны зээлийн багцын хэмжээ 76 хувиар өсч, 39.5 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн түүнчлэн Орон Сууцны Санхүүжилтийн Корпорацитай хамтран Засгийн Газрын “40 000 айлын орон сууц” хөтөлбөрийг идэвхитэй дэмжин хамтран ажиллаж байна.


Илүү боловсронгуй гэгдэх санхүүгийн системийн хариуцлагагүй, хэт ашгийн төлөө үйл ажиллагаанаас моргейжээр баталгаажсан үнэт цаасны нэр хүнд унасан хэдий ч бид төгрөгт суурилсан, өндөр чанар бүхий моргейж зээлүүдээр баталгаажсан 1 тэрбум төгрөгийн үнэт цаасыг Монгол Улсад анх удаа Монголын Орон Сууцны Санхүүжилтийн Корпорацитай хамтран Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан гаргалаа. Энэ нь Голомт банкны зүгээс бондын зах зээлийг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийн нэг хэсэг юм.

Одоогоос арван жилийн өмнө Монгол Улсад төлбөрийн картын системийг анхлан нэвтрүүлсэн манай банк картын бизнесийн үйл ажиллагаагаа үр дүнтэй өргөжүүлж, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлсэний үр дүнд 2008 онд карт эзэмшигчдийн тоо 46 хувиар, картын гүйлгээний хэмжээ 45 хувиар өсч, Монгол дахь картын системийн 60 гаруй хувийг дангаараа бүрдүүлж байна.

Хэрэглээний зээл (тэрбум төгрөг)



Орон сууцны зээл (тэрбум төгрөг)



БАЙГУУЛЛАГАД ХАНДСАН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Байгууллагын бизнест хандсан банкны үйлчилгээний үндсэн зорилго нь Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа том, жижиг аж ахуйн нэгж, байгууллагуудын аль алиных нь хамгийн найдвартай санхүүгийн түнш байж, тэдэнд бизнесийн онцлог, хэрэгцээ шаардлагад нь нийцсэн санхүүгийн иж бүрэн үйлчилгээг үр ашигтай, уян хатан нөхцлөөр хүргэх юм.

Дэлхийн санхүүгийн хямралын шууд болон шууд бус нөлөөлмөөс улбаалан улс орны эдийн засаг аливаа бизнесийн үйл ажиллагаанд таатай бус байгаа энэ үед манай банк харилцагчиддаа уламжлалт санхүүгийн үйлчилгээнүүдээ тасралтгүй хүргээд зогсохгүй бусад өндөр түвшний үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Энэхүү үйлчилгээ нь бизнес төлөвлөлтөө үр ашигтай хийх замаар санхүүгийн удирдлага, санхүүгийн чадавхиа бэхжүүлэн сайжруулахад нь тус дөхөм болохуйц

харилцагчдад зориулсан сургалтын хөтөлбөрүүд болон бизнесийн үйл ажиллагаа, удирдлагын бологод чухал шаардлагатай, үр ашигтай санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нь зуучлах зэргээр олон төрлийн нэмэлт үйлчилгээг үзүүлж байна.

Мөн түүнчлэн олон улсын нэр хүндтэй байгууллага болох Олон Улсын Агаарын Тээврийн Холбоо (IATA)-ны итгэлийг хүлээн Монгол Улс дахь төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх албан ёсны банкаар сонгогдлоо.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар нь аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 64.6 хувь, ДНБ-ий 28.2 хувийг эзэлдэг Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн гарцыг тодорхойлох өндөр ач холбогдолтой салбар болоод байна. Сүүлийн жилүүдэд стратегийн ач холбогдол бүхий томоохон орд газрууд олноор нээгдэж, энэ салбарт бизнес эрхлэгчдийн тоо улам бүр нэмэгдсээр байна. Тиймээс уул уурхайн салбарт бизнес эрхэлж буй харилцагч байгууллага, иргэдэд салбарын онцлогт нийцсэн банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээг үзүүлэх зорилго бүхий, мэргэшсэн экспертүүдээс бүрдсэн Уул уурхайн хэлтсийг Байгууллагын банкны газрын харъяанд байгууллаа.



ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ, ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦОО

Олон улсын тэргүүлэгч банкуудтай корреспондент банкны харилцаа холбоогоо өргөжүүлж, гадаад худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын үйлчилгээг амжилттай хэрэгжүүлснээр манай худалдааны санхүүжилтын хэмжээ өмнөх оноос даруй 200 гаруй хувиар өсч Монгол Улс руу орж ирэх санхүүжилтийн үндсэн эх үүсвэрийг хангагч байр сууриа хадгаллаа. Тайлант онд бид шинээр дэлхийд тэргүүлэгч HSBC Australia Limited, Bank of China, China Construction Bank, Canadian Imperial Bank of Commerce, Standart Chartered Bank, Тайваны Exim Bank, Bank Napoalim, Wachovia Bank N.A, (A Wells Fargo Company), болон ОХУ-ын Хөдөө Аж Ахуйн Банктай корреспондент банкны хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ Японы Сумитомо Мицуй банк, Финляндын Nordea банк, Олон Улсын Санхүүгийн Корпораци болон ОХУ-ын Хөдөө аж ахуйн банкнаас шинээр олгосон худалдааны санхүүжилтийн зээлийн шугамыг ашиглан гадаад худалдаа эрхэлдэг харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.

Банк нь Дэлхийн банкны гишүүн болох Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Глобал худалдааны санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсаны зэрэгцээ Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкт хамтын санхүүжилтийн гэрээг амжилттай байгууллаа.

Бид харилцагч банкуудаараа дамжуулан олон улсын төлбөр тооцоо гүйцэтгэхээс гадна 200 гаруй улс оронд үйл ажиллагаа явуулдаг шуурхай мөнгөн гуйвуулгын дэлхийн томоохон, нэр хүнд бүхий Western Union сүлжээгээр дамжуулан олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үзүүлж байна.

Хятадын юань гадаад төлбөр тооцоонд өргөнөөр ашиглагддаг ба 2008 онд Монгол Улсын нийт гадаад худалдааны 46 хувь нь БНХАУ-тай хийгдсэн байна. Голомт Банк нийт юаниар хийгдэх төлбөр тооцоонд тэргүүлэгч бөгөөд 2008 онд банкны юанийн төлбөр тооцооны эргэлт өмнөх онтой харьцуулахад 50 хувиар өсч Хятад улстай хийх төлбөр тооцооны 60 хувийг дангаар гүйцэтгэж байна. Энэхүү чухал ач холбогдолтой салбарт үйлчлэх үйлчилгээний хурд, үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс БНХАУ-ын Тариалангийн Банк (Agricultural Bank of China), Аж Үйлдвэр Худалдааны Банкуудтай (ICBC) “Интернэтээр төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ” байгуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлээ.

Банк нь Бээжин болон Лондон хот дахь төлөөлөгчийн газрын хамтын ажиллагаа, дэмжлэгээс ихээхэн үр өгөөжийг хүртсээр байна.

НӨӨЦИЙН БОЛОН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хоёрдугаар сард Голомт Банк дэлхийд тэргүүлэгч Кредит Свисс банктай 5 жилийн хугацаатай, 20,000,000 ам долларын хоёрдогч өглөгийн гэрээ байгуулсан ба энэ нь банкны хувьд 2 дугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө болох юм. 1995 онд байгуулагдсанаасаа хойш цорын ганц хувь нийлүүлэгчтэй явж ирсэн Голомт банкны хувьд энэхүү үйл явдал нь, Монголын худалдаа үйлдвэрлэлийн тэргүүлэгч компани Бодь Группээс гадна хоёрдогч хувьцаа эзэмшигчтэй болох боломжийг нээсэн санхүүгийн хэрэгсэл гаргаж буй анхны тохиолдол юм.

Тайлант оны аравдугаар сард Голомт Банк Бүгд Найрамдах Итали улсын тэргүүлэгч банк Интеса СанПаоло банктай Итали болон Монгол Улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой хамтын ажиллагааны гэрээ байгуулав. Уг гэрээг байгуулснаар хоёр орны аж ахуйн нэгж байгууллагууд эдгээр байгууллагуудаар дамжуулан худалдаа хөрөнгө оруулалтын санхүүжилт авах, томоохон бизнесийн төслүүдийг хамтран хэрэгжүүлэх боломжтой болсон билээ.


Мөнгөний захын үйл ажиллагаа

Банк санхүүгийн салбарт тэргүүлэгч, төлбөрийн чадвар хамгийн сайтай банкны хувьд бид банк хоорондын зах зээлд томоохон байр суурь эзэлж, Төв банкны үнэт цаасны арилжаа болон Засгийн Газрын бондын арилжаанд идэвхитэй оролцож байна.

Гадаад актив, валютын арилжаа

2008 оны эцсийн байдлаар Монголын банкны системийн хэмжээнд нийт 294.5 тэрбум төгрөгийн гадаад актив буюу бэлэн гадаад валют, гадаадын банкинд байршуулсан харилцах, хадгаламж, гадаадын үнэт цаас, гадаадын банк болон оршин суугч бусад олгосон зээл байгаагийн 50 хувь нь Голомт банкинд байршиж байна.

Банкны системийн гадаад активд эзлэх Голомт банкны хувь



Өнгөрсөн жилийн сүүлээр зах зээлийн нөхцөл байдал хүндэрч байх үед Банк гадаад дотоод дахь харилцагч түнш байгууллага, үйлчлүүлэгчидтэйгээ харилцаа, хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, зах зээлийн хандлага, нөхцөл байдалд зөв бодитой үнэлгээ өгөх, өөрчлөгдөн буй орчинд баримтлах бодлого, үйл ажиллагааны арга тактикийн талаар зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж ирлээ. Үүний үр дүнд бид зах зээл дээр хүүгийн өөрчлөлтөөс хамгаалах зорилгоор болон гадаад валютын спот, форвард, хэджинг арилжаагаар тэргүүлэх байр сууриа хадгалж ирлээ.

Бид Монголбанкны итгэлийг хүлээж, тэдний өгсөн чиглэлийн дагуу мөнгөний бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс гадаад валютын дотоодын зах зээлд идэвхитэй оролцож төгрөгийн худалдан авах чадварын хэлбэлзлийг тогтворжуулах арга хэмжээ авч ирсэн боловч жилийн эцэст манай улсын экспортын хэмжээ, үнэ огцом унаснаар гадаад валютын нөөц эрс буурахад хүрсэн.

Гадаад орчин харьцангуй таатай бус байсан ч бид уул уурхайн салбарын харилцагчдаасаа 1.1 тонн орчим алт худалдан авч Төв банкинд байршуулах болон худалдах үйл ажиллагаа явуулсан болно.

Санхүүгийн үр дүн




Олон улсын болон Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй байсан хэдий ч Голомт банкны хувьд 2008 он тайлан тэнцлийн болон ашигт ажиллагааны хувьд ихээхэн амжилттай жил байлаа.


2008 оны эцэст Банкны нийт актив өмнөх оноос 652 тэрбум төгрөгөөс 45 тэрбум төгрөг (7 хувь)-өөр өсч 697 тэрбум төгрөгт хүрэв. Энэхүү өсөлт нь 2008 оны Монголын банкны системийн нийт активын өсөлтийн 17 хувь юм.

Харилцагчдад олгосон цэвэр зээл өмнөх оноос 125 тэрбум төгрөгөөр өсч 448 тэрбум төгрөгт хүрсэн ба богино хугацааны өндөр өртөгтэй хадгаламж, эх үүсвэрээс зайлсхийх бодлогын үр дүнд хадгаламжийн хэмжээ тогтвортой байж цэвэр хүүгийн ахиуц, ашигт ажиллагааны харьцаанууд сайжирлаа.


Нийт актив (тэрбум төгрөг)




Харилцагчдын харилцах, хадгаламж (тэрбум төгрөг)



Цэвэр зээл (тэрбум төгрөг)



Чанаргүй зээлийн хувь хэмжээ (%)




Чанаргүй зээлийн хувь 4.2 хувиас 3.9 болж буурсан бол чанаргүй зээлийн 83.9 хувьд зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан байгуулагдаж, үлдсэн хэсэг нь барьцаа хөрөнгөөр бүрэн хамгаалагдаж байна.


Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө 12.2 тэрбум төгрөгөөр буюу 32 хувиар өсч 50.9 тэрбум төгрөгт, нийт өөрийн хөрөнгө 8.7 тэрбум төгрөгөөр өсч 63.5 тэрбум төгрөгт тус тус хүрсэний дүнд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 10.3 хувь, нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 12.8 хувь болж, Монголбанкнаас тогтоосон байвал зохих доод хязгаараас 30 орчим хувиар өндөр түвшинд хангагдсан байна.

Санхүүгийн үр дүн (үргэлжлэл)

Нийт өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)



2008 оны эцэст Голомт Банк банкны системийн нийт харилцагчдын харилцах, хадгаламжийн 22 хувь, нийт активын 19 хувь, цэвэр зээлийн 17 хувь, нийт өөрийн хөрөнгийн 19 хувийг бүрдүүлж байна.

2008 онд үйл ажиллагааны орчин адармаатай байсан хэдий ч Банк уламжлалт хөрвөх чадвар, актив пассивын бодлогоо баримтлан ажилласнаар оны эцэст хөрвөх чадварын харьцаа 37 хувь гарсны дээр цэвэр зээл нийт харилцах, хадгаламжийн харьцаа 89 хувь байгаа нь банкны системийн дундаж 113 хувиас харьцангуй бага байна.

Орлогын талаас нь үзвэл, нийт хүүгийн орлого 24.7 тэрбум төгрөгөөр буюу 55 хувиар өсч 69.3 тэрбум төгрөгт хүрсэн бол хүүгийн зардал үүнээс бага буюу 13.3 тэрбум төгрөг, 44 хувиар өсч 43.5 тэрбум төгрөгт хүрэв. Ийнхүү цэвэр хүүгийн орлого 11.4 тэрбум төгрөгөөр буюу 80 хувиар өссөн нь бидний авч хэрэгжүүлсэн хүүгийн үр ашигтай бодлогын үр дүн юм.


Цэвэршүүлж тооцоолсон хүүгийн бус орлого 23.2 хувь, 1.7 тэрбум төгрөгөөр өсч 8.9 тэрбум төгрөгт хүрэв.

Үйл ажиллагааны зардал 5.1 тэрбум төгрөгөөр өсч 15.2 тэрбум төгрөгт хүрсэн. Боловсон хүчний зардал 1.8 тэрбум төгрөгөөр буюу 68.4 хувиар өссөн нь гүйцэтгэлд суурилсан урамшууллын өсөлтөөс голлон шалтгаалжээ. Биет болон биет бус хөрөнгийн элэгдлийн зардал 0.5 тэрбум төгрөг (27 хувь), түрээсийн зардал 0.5 тэрбум (36 хувь) төгрөгөөр тус тус өсчээ.


Татварын дараах ашиг өмнөх онтой харьцуулахад 4.8 тэрбум төгрөг, 65 хувиар нэмэгдэж 2008 онд 12.2 тэрбум төгрөгт хүрлээ. Энэхүү өсөлт нь төвлөрсөн актив пассивын бодлого, үр ашигтай зардлын удирдлагын үр дүнд гарсан бүхий л төрлийн орлогын эх үүсвэр болон тоо хэмжээний өсөлт, үр ашигтай үйл ажиллагааны үр дүнд бий болсон байна. Нөгөө талаас үйл ажиллагааны үр ашигт байдлыг харуулах гол үзүүлэлтүүд эдгээрийг баталж, зардал орлогын харьцаа 2006 онд 50 хувь, 2007 онд 46.7 хувь байсан бол 2008 онд 43.8 хувь болж буурсны зэрэгцээ ажилчдын тоо жилд 146-гаар өссөн боловч татварын дараах байдлаар нэг ажилтанд ноогдох ашиг 38 хувиар нэмэгдэж 14 сая төгрөгт хүрсэн байна.

Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 2007 онд 17.3 хувь байсан бол 2008 онд сайжирч 24.3 хувь болсон бол дундаж активын өгөөж татварын дараах байдлаар 20 нэгж хувиар өсч 1.8 хувьд хүрлээ.


Татварын дараах ашиг (сая төгрөг)




Нэг ажилтанд ногдох ашиг (мянган төгрөг)



Дундаж активын өгөөж (%)




Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)




Ашигт ажиллагааны өсөлтийг дагаад татварын зардал 2007 онд 1.8 тэрбум төгрөг байснаас 2008 онд 1.5 тэрбум төгрөг буюу 83 хувиар нэмэгдэж 3.3 тэрбум төгрөгт хүржээ.

Зардал, орлогын харьцаа (%)



Цэвэр хүүгийн ахиуц (%)



ТАВАН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Доорх хүснэгтэнд Голомт банкны 2004 оны 1 дүгээр сараас 2008 оны 12 дугаар сар хүртэл хугацааны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг харуулав.

	2004	2005	2006	2007	2008
Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Нийт актив	183,417	273,253	353,161	652,051	697,179
Нийт харилцах, хадгаламж	147,125	232,838	283,707	512,485	505,171
Цэвэр зээл	90,943	131,817	174,700	323,026	447,787
Нийт өөрийн хөрөнгө	14,590	20,275	35,794	54,871	63,548
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	14,111	19,632	26,955	44,564	69,318
Хүүгийн зардал	(8,374)	(13,284)	(18,283)	(30,228)	(43,569)
Цэвэр хүүгийн орлого	5,737	6,348	8,672	14,336	25,749
Цэвэр хүүгийн бус орлого	3,200	4,249	3,698	7,231	8,912
Үйл ажиллагааны зардал	(3,714)	(4,450)	(6,179)	(10,078)	(15,178)
Эрсдэлийн сангийн зардал	(2,689)	(2,708)	(2,563)	(2,299)	(3,958)
Татварын зардал	(782)	(1,057)	(1,109)	(1,811)	(3,324)
Татварын дараах ашиг	1,752	2,381	2,520	7,378	12,201
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж/ Нийт актив	80.2%	85.2%	80.3%	78.6%	72.5%
Өөрийн хөрөнгө (1-р зэрэглэл)/Нийт актив	8.0%	7.4%	8.9%	5.9%	7.3%
Цэвэр зээл/ Нийт актив	49.6%	48.2%	49.5%	49.5%	64.2%
Цэвэр зээл/Нийт харилцах, хадгаламж	61.8%	56.6%	61.6%	63.0%	88.6%
Чанаргүй зээлийн харьцаа (%)	8.4%	8.6%	6.7%	4.2%	3.9%
Хөшүүргийн харьцаа (дахин)	11.6	12.5	8.9	10.9	10.0
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	1.2%	1.1%	0.8%	1.6%	1.8%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	15.1%	14.4%	10.7%	17.3%	24.3%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	5.4%	3.8%	4.0%	4.1%	4.2%
Зардал, орлогын харьцаа (%)	41.6%	42.0%	50.0%	46.7%	43.8%
Нэг ажилтанд ноогдох ашиг (мянган төгрөг)	5,277	5,807	4,598	10,134	13,960
Эрсдэлийн үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >10%	13.1%	12.3%	16.7%	14.4%	12.8%
Нийт гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд <+/-40%	20.6%	32.4%	39.7%	8.1%	11.9%
Нэг зээлдэгч түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <20%	18.6%	18.3%	18.3%	17.5%	19.5%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <5%	0.8%	0.1%	2.0%	2.7%	3.7%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >= 18%	50.5%	51.7%	53.2%	49.3%	37.0%
Үндсэн хөрөнгийн харьцаа <=8%	1.4%	1.2%	1.1%	1.0%	1.0%

Эрсдэлийн удирдлага ба хяналт



2008 онд дэлхий дахинд өрнөсөн үйл явдал нь бусад салбаруудтай харьцуулахад банкны салбарт зөв зохистой үйл ажиллагаа, эрсдэлийн оновчтой удирдлага хамгийн чухал гэдгийг тодхон харууллаа. Банкнаас гадна цөөн хэдэн салбарын хувьд урт хугацааны бизнесийн амжилтанд эрсдэлийг тооцоолох, тодорхойлох, арилгах асуудал чухлаар тавигддаг бөгөөд энэхүү үйл явцад Эрсдэлийн Удирдлагын газар хамгийн чухал үүргийг гүйцэтгэдэг.

Бизнесийн орчинд үүссэн хүчтэй уналт, эмзэг байдлын эсрэг арга хэмжээ авах, нөхцөл байдлыг хохиролгүйгээр даван туулахын тулд бид эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаагаа илүү хүчирхэгжүүлж ажиллав. Банкны холбогдох бүх нэгжүүд зээлдэгчтэй нягт хамтран, тэднийг дэмжин ажиллахын зэрэгцээ санхүүгийн тодорхойгүй нөхцөл байдалд хэрхэн ажиллах, хэрхэн давуу тал олох болон санхүүгийн сахилга батыг хэрхэн хамгийн өндөр түвшинд сахих талаар сургалт, зөвлөгөөг байнга зохион байгуулж байна.

Голомт Банкны хувьд банкны үйл ажиллагааны бүхий л түвшинд эрсдэлийг хянах, удирдах үйл ажиллагааг тасралтгүйгээр зохион байгуулах, хэрэгжүүлэх үүргийг банкны бүтцийн бие даасан нэгж болох Эрсдэлийн Удирдлагын газар гүйцэтгэж, Гүйцэтгэх захиралд шууд тайлагнаж байна.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Голомт банкны зээлийн бодлого нь банк, зээлдэгчийн аль алинд харилцан ашигтай нөхцөлийг бүрдүүлэх замаар зээлийн зуучлалын үйл ажиллагаан дахь зээлийн эрсдэлийг боломжит хамгийн бага түвшин хүртэл бууруулахад чиглэгддэг. 2008 оны эдийн засгийн уналтын үед банк голлох зээлийн бодлого, журмуудаа хэвээр үргэлжлүүлсэн хэдий ч эрсдэлийн хязгаарлалт, зээлдэгчдэд тавигдах шаардлагуудыг илүү нарийсгаж, эрсдэлийн хяналтыг чангатган ажиллав.


Зээлийн эрсдэлийн загварчлал ба багцын чанар

2004 оноос хойш бид зээлийн хугацаа хэтрэлт (PD), алдагдлын магадлал (LGD) болон зээлийн эрсдэлийн бусад үзүүлэлтүүдийг тооцоолох загварчлалыг боловсруулан ашиглаж байна. Уг аргачлал нь IAS 39 болон Базелын хорооноос гаргасан Зээлийн эрсдэлийн загварчлалын шаардлагуудыг бүрэн хангасны үндсэн дээр хөндлөнгийн хяналтын Ernst & Young компаниар баталгаажуулагдан, хүлээгдэж буй хугацаа хэтрэлт, алдагдлын хэмжээг тооцоолон, зээлийн эрсдэлийн хязгаарлалтууд, бусад зохист параметруудыг тогтоох замаар зээлийн эрсдэлийг хянах үр ашигтай хэрэгсэл гэдэг нь батлагдсан болно.

Эрсдэлийн удирдлага ба хяналт (үргэлжлэл)

Графикаас харахад 2008 онд зээлийн хугацаа хэтрэлт (PD) 3.2-аас 1.9, алдагдлын магадлал (LGD) 0.3-аас 0.1 болж тус тус буурчээ. Өндөр түвшний зээлийн судалгаа, оновчтой шийдвэр гаргалт болон тасралтгүй үр ашиг бүхий хяналтын тогтолцооны үр дүнд бид хямралын хүнд нөхцөлд ч зээлийн багцын чанараа хэвээр хадгалж чадсан бөгөөд 2008 оны эцэст, нийт багц дахь чанаргүй зээлийн хувь хэмжээ 3.9 хувь болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувиар буурсан байна.


Зээлийн загварчлал



Салбарын шинжилгээ ба төвлөрөл

Зээлийн багцын чанарыг урьдчилан тодорхойлсон түвшинд барих үүднээс төвлөрлийн хязгаарлалтыг тогтоож, хэрэгжүүлдэг. Бизнесийн нэг салбарт, эсвэл эдийн засгийн аль нэг сегментэд зээлийн хэт төвлөрөл үүсэхээс зайлсхийхийн тулд банкны зээлийн бодлогод эдийн засгийн нэг салбарт олгох зээлийн дээд хэмжээг нийт багцын 30 хувиас хэтрэхгүй байхаар заасан бөгөөд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ, холбоотой буюу групп зээлдэгчдэд олгох зээлийн дээд хэмжээ болон рейтинг, улс орны хязгаарлалт зэрэг үзүүлэлтүүд ч зээлийн бодлогод тусгагдсан байдаг. 2008 оны эцэст банкны нийт зээлийн багц 657 тэрбум төгрөг (518 сая ам.доллар) болж, өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өссөн байна

Банкны актив хөрөнгө эдийн засгийн салбараар (тэрбум төгрөг)



ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛ

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь банк өөрийн санхүүгийн үүргүүдээ цаг хугацаанд нь зах зээлийн үнээр гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэл юм. Санхүүгийн үүргүүд гэдэгт хадгаламж эзэмшигчдэд өгөх өглөг, санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний дагуух төлбөрүүд, үнэт цаас, зээл, худалдан авалтын төлбөр тооцоонууд болон хөрөнгө оруулалт, зээлтэй холбоотой бүхий л үүргүүдийг ойлгоно.

Голомт банкны хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо нь зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд дээр дурьдсан санхүүгийн үүргүүдээ бүрэн гүйцэтгэж чадахуйц хөрвөх чадварын баталгаат түвшингүүдийг тогтоох, хянах, удирдахад чиглэдэг. Актив пассивын хороо нь банкны хөрвөх чадварын эрсдэлд хандах хандлагыг тусгасан, холбогдох дүрэм, журам болон олон улсын шалгарсан практикт нийцсэн хөрвөх чадварын эрсдэлийн стандартуудыг тогтоодог ба энэ нь банкны хэмжээнд мөрдөгдөх хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хэм хэмжээ болдог. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого, журмуудын хэрэгжилтийг хангуулах үүргийг Актив пассивын хороо гүйцэтгэдэг.


Банкны хөрөнгийн удирдлагын нэгдсэн бодлогын дагуу Актив пассивын хороо хөрвөх чадварын цогц удирдлагын доорх элементүүдийг хэрэгжүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Урт, богино хугацааны мөнгөн урсгалын удирдлага;
- Балансын зөв, сайн бүтцийг тогтоох, хадгалах;
- Гадаад валютын хөрвөх чадварын удирдлага;
- Эх үүсвэрийг хангалттай тархах, төвлөрлийг багасгах;
- Хөрвөх чадварын стресс тестийг тогтмол хийх;
- Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Өргөн хүрээтэй дотоод хяналтын системийн тусламжтайгаар дээрх элементүүдийн өөрчлөлт, тэдгээрийн нөлөөллийг сард 2 буюу түүнээс дээш удаа хянаж, дүгнэн үр дүнг Актив пассивын хорооны хуралд танилцуулдаг. Энэхүү дотоод хяналтын систем нь зорилтот технологиуд, батлагдсан дүрэм журмуудын хэрэглээ болон системийн үр ашигт байдлыг үнэлэх эрсдэлийн удирдлагын бие даасан, гэнэтийн болон тогтмол хяналтыг агуулдаг.

Доорх хүснэгтэд банкны хөрвөх чадварын харьцааг, графикт хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны шинжилгээний үр дүнг харуулав.

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ



Хөрвөх чадварын харьцаа	2007	2008
12 дугаар сарын 31	49.3%	37.0%
Жилийн дундаж	53.0%	41.0%
Хамгийн өндөр	59.3%	48.4%
Хамгийн бага	49.3%	30.9%

Мөнгөн урсгалын удирдлага

Үр ашиг бүхий идэвхтэй хөрөнгийн удирдлага нь хэд хэдэн бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааг хамардаг бөгөөд Хөрөнгийн удирдлагын газарт удирдагддаг. Богино хугацааны мөнгөн урсгалын төсөөлөл нь банкны бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах шаардлагаар төлөвлөгддөг бөгөөд Актив пассивын хорооны шаардлагууд, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг агуулсан байдаг. Харин урт хугацааны төлөвлөлтийн хэрэгцээ нь төсөөлсөн балансын бүтэц, санхүүгийн хэрэгслүүдийн байршлыг зохицуулах шаардлагаас урган гарч, тогтмол хугацаанд шалгагдан, сайжруулагдаж байдаг.

Бүтцийн шаардлагууд

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ нь хөрвөх чадварыг балансын бүтцээр удирдах үр ашигтай цогц удирдлагын тогтолцооны суурь болдог. Хүлээгдэж буй мөнгөн урсгал нь эргэн төлөгдөх хугацаа өөрчлөгдөх бүрт материаллаг дүнгээр өөрчлөгдөж байдаг. Иймд банкны хөрөнгө, эх үүсвэр болон тэнцлийн гадуурх үүргүүдийг эргэн төлөгдөх хугацааны хувьд шинжлэхдээ хугацаа нь тодорхойгүй, эсвэл хугацаанаас өмнө хэрэгжих магадлалтай үүргүүдийг мөн чанарын хувьд ангилж, хугацааны боломжуудыг тодорхойлдог. Энэхүү үйл явц нь балансын бүтэц алдагдсанаас үүсэх хөрвөх чадварын эрсдэлийн хэмжээ, түүнийг нөхөхөд зарцуулагдах нэмэлт эх үүсвэрийн хэмжээг тодорхойлоход ашиглагддаг.

Хугацааны ялгаатай үеүд дэх хүлээгдэж буй орох, гарах хөрөнгийн урсгалын зөрүүг тодорхой хязгаарт барих, хөрвөх чадварын харьцааг хангалттай өндөр түвшинд байлгах үүднээс зохих хязгаарлалт, шаардлагуудыг тогтоон мөрддөг. Энэхүү хязгаарлалт, шаардлагуудыг хангуулах үр ашиг бүхий механизмудын нэг нь богино хугацааны хөрөнгө, эх үүсвэрийг харьцаа (Short-term funding ratio)-г тогтоож, үр ашигтайгаар удирдах юм.

Эрсдэлийн удирдлага ба хяналт (үргэлжлэл)

Гадаад валютын хөрвөх чадварын удирдлага

Валютын ханш эсвэл тухайн валютын балансын бүтэц өөрчлөгдөх үед банкны гадаад валютын хөрвөх чадварт өөрчлөлт гардаг. Валютын хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх гол түлхүүр нь гадаад валютаар олгох зээлийн хэмжээг тухайн валютаар татсан эх үүсвэртэй уялдуулах явдал юм.

Төвлөрөлгүй багц буюу хөрөнгийн тараан байршуулалт

Банкны хөрөнгө, эх үүсвэрийг эдийн засгийн секторууд болон том, групп харилцагчдаас хэт хамааралтай болохоос урьдчилан сэргийлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор төвлөрлийн эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоодог. Эх үүсвэрийн дийлэнхийг урт хугацаат зээллэг болон харилцагчдын оновчтой хольцоос (том, жижиг харилцагчдын хувьд) бүрдүүлэх замаар төвлөрлийн эрсдэлийг бууруулдаг.

Хөрвөх чадварын стресс тест

Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас банкны хөрвөх чадварт үүсч болзошгүй нөлөөллийг үнэлэх зорилгоор тусгайлан болон системчилсэн стресс сценариудыг гарган, тэдгээрт нийцсэн мөнгөн урсгалын төсөөлмүүдийг хийдэг. Сценариуд нь түүхэн эсвэл төсөөлсөн үйл явдал (жишээ нь нэг банк хүндэрсэн нь түүхэн үйл явдал бол үүнээс системд үзүүлэх нөлөөллийг тооцоолох нь төсөөлсөн үйл явдал юм)-ын аль алинд суурилж болох бөгөөд стресс тестийн үр дүнгүүд нь хөрвөх чадварын зорилтот түвшингүүдийг тодорхойлох, төлөвлөхөд хамгийн зөв, оновчтой өгөгдлүүд болдог.

Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөө

Эдийн засаг зогсонги байдалд орсонтой холбоотойгоор банк хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ нь хөрвөх чадварын хүндрэлийг хохиролгүйгээр даван туулахуйц түвшний итгэлцлийг зах зээлд бий болгох, хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн цогц төлөвлөгөө бөгөөд хямралын үед баримтлах тодорхой стратегит суурилсан, хямралыг урьдчилан мэдээлэх өргөн хүрээтэй үзүүлэлтүүдийг агуулсан байдаг. Урьдчилан мэдээлэх үзүүлэлтүүд нь тодорхой давтамжтайгаар, нарийвчлалын өндөр түвшинд хянагдан шинэчлэгддэг бол хямралын эсрэг стратеги нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд зохион байгуулагдаж, дотоод гадаад харилцаа, хөрвөх чадвар болон нөхцөл байдлын шаардлагаар бий болох нэмэлт мэдээллийн шаардлагуудыг тусгасан байдаг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Зах зээлийн эрсдэл нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш, өөрийн хөрөнгийн үнэ цэнэ гэх мэт зах зээлийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн сөрөг өөрчлөлтийн нөлөөгөөр банкинд үүсч болзошгүй эрсдэл юм. Банк арилжааны болон арилжааны бус багцын аль алинаас нь зах зээлийн эрсдэлд өртөж болох бөгөөд энд банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа ч хамаардаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс банкны эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зах зээлийн эрсдэлийн ерөнхий хязгаарлалт болон түүнд агуулагдах үзүүлэлт нэг бүрийн нарийвчилсан хязгаарлалтуудыг тогтоож, хэрэгжилтийг Актив пассивын хороо хянадаг. Энэхүү хяналт нь банк одоо болон ирээдүйд хүү, ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох эрсдэлийн нийт багцыг тодорхойлох, тогтмол хянах зарчмаар хийгддэг.

Хөрөнгийн удирдлагын газрын захирал Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Актив пассивын хорооноос тогтоосон бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах, бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын төрлүүд, арилжааны хэлцлүүд болон санхүүгийн хэрэгслүүдийн хувьд тавигдсан хязгаарлалтуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох замаар зах зээлийн эрсдэлийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгэдэг.

Эрсдэлийн удирдлагын газар нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд голлох үүрэгтэйгээр оролцож үйл ажиллагаагаа Актив пассивын хороо болон Гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг.

Хүүгийн эрсдэл

Банкны арилжааны бус багцаас урган гардаг зах зээлийн гол эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс банкны ашиг, эсвэл өөрийн хөрөнгөд үзүүлэх сөрөг нөлөөлөл буюу хүүгийн түвшний эрсдэл юм. Бид дараах шалтгаануудын улмаас хүүгийн түвшний эрсдэлд өртдөг.

- Хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлэгдэх эсвэл эргэн төлөгдөх хугацаа ялгаатай байх (жишээ нь, хөрөнгө эх үүсвэрээс хурдан хугацаанд дахин үнэлэгддэг тохиолдолд хүүгийн түвшин буурах нь ашгийг бууруулна);
- Хөрөнгө, эх үүсвэр ижил хугацаанд ялгаатай дүнгээр дахин үнэлэгдэх (жишээ нь, зах зээл дэх хүүгийн түвшин буурч байхад хугацаагүй хадгаламжинд төлөх хүүгийн хувийг зах зээлийн хүүгийн түвшний бууралтаас бага дүнгээр бууруулах);
- Урт, богино хугацааны зах зээлийн хүүгийн түвшин ялгаатай дүнгээр өөрчлөгдөх (жишээ нь, өгөөжийн муруй шинээр олгогдож буй зээлийн өгөөж болон эх үүсвэрийн зардалд өөрөөр нөлөөлөх);
- Хүүгийн түвшний өөрчлөлтөөс хөрөнгө, эх үүсвэрийн үлдсэн хугацаа уртсах эсвэл богиносх (жишээ нь, хэрэв урт хугацаат моргейжийн хүү огцом буурвал моргейж төлөвлөсөн хугацаанаас эрт ихээр төлөгдөж, орлого буурна).

Хүүгийн түвшний эрсдэлийг хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлгээний зөрүүгээр үүссэн хүүгийн мэдрэмжийн зөрүү дүнг шинжлэх замаар тооцоолж болно. Доорх хүснэгтэд хүүгийн түвшний болзошгүй өөрчлөлтөөс орлогын тайланд үзүүлэх нөлөөллийг оны эцсийн өгөгдлүүдэд суурилан үзүүлээ.

	Хүүгийн өөрчлөлт	Ашигт үзүүлэх нөлөө
2008	+120	-3.96%
2008	-120	3.96%
2007	+90	-8.04%
2007	-120	8.04%

Гадаад валютын эрсдэл

Арилжааны багцын гол эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хүү, зах зээл дэх хөрвөх чадвар, үнийн өөрчлөлтөөс болдог. Арилжааны багцаас хүлээх эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хэмжээ, зах зээл дэх хөрвөх чадвар болон үнийн өөрчлөлтөөс голлон үүсэх бөгөөд эрсдэлийн үндсэн хүчин зүйлүүд нь хүүгийн түвшин, ханш, хувьцааны үнэ юм.


Банкны арилжааны үйл ажиллагааны гол цөм нь харилцагчдад өрсөлдөхүйц үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлэх буюу харилцагчид чиглэсэн үйл ажиллагаа юм. Үүнээс гадна банк ашиг олох зорилгоор өөрөө янз бүрийн арилжааг хийдэг бөгөөд тухайлбал, зах зээлийн давуу байдлаа ашиглан авах зарах үнийн зөрүүгээр ашиг олох зорилгоор валютын арилжаа хийх, хоорондоо холбоотой өөр өөр зах зээлийн төгс бус байдлаас ашиг олох зорилгоор позици үүсгэх, ирээдүйд давуу тал олох зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмших гэх мэт.

Бизнесийн үйл ажиллагааныхаа явцад зах зээлийн эрсдэлтэй холбогддог банкны бүтцийн бүхий л нэгжүүд банкны арилжааны бодлогыг дагаж мөрдөх ёстой. Зах зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь нарийвчлан тогтоосон, хатуу хязгаарлалтууд бөгөөд эдгээр нь дилерийн эрх хэмжээ гэх мэт эрсдэлийн удирдлагын үндсэн үзүүлэлтүүдийг бүхэлд нь тогтоосон байдаг. Хязгаарлалтууд зөрчигдсөн тохиолдолд авах авах арга, хэмжээнүүдийг арилжааны бодлогод мөн тусгасан байдаг.

Бид зах зээлийн эрсдэлийг тооцоолохдоо гурван төрлийн VaR (Value at Risk) аргыг ашигладаг. VaR нь тодорхой хугацааны хязгаарт багцын зах зээлийн үнэлгээнд гарч болох боломжит сөрөг өөрчлөлтийг өгөгдсөн итгэх түвшинд тооцоолдог техник юм. Бид Төв банкны зохистой харьцааны шаардлагын дагуу VaR-г 10 хоногийн хугацаанд 99 хувийн итгэх засварт тооцоолохын зэрэгцээ 1 өдрийн дотор 99 хувийн итгэх завсарт тооцоолон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа ашигладаг. Түүнчлэн VaR аргаар тооцоологдох боломжгүй алдагдлыг тодорхойлох зорилгоор стресс тестийг хийдэг.

Эрсдэлийн удирдлага ба хяналт (үргэлжлэл)

Доорх зурагт 99 хувийн итгэх завсарт, 1 өдрийн хугацааны хязгаартайгаар, өмнө дурдсан 3 төрлийн VaR аргаар хийсэн тооцооллын үр дүнг нэгтгэн харуулав. EVT VaR нь стресс тестийн үр дүнг харуулна.



Түүнчлэн, бид VaR аргаар тооцоолсон үр дүнгүүдийг арилжааны явцад үүссэн бодит ашиг, алдагдалтай тулган буцаан шалгах буюу backtesting-г өдөр бүр програмчлалын тусламжтайгаар хийж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь дүрэм журам системийн нийцгүй байдал эсвэл үл хэрэгжилт, хүний санамсаргүй алдаа, санаатай үйлдлүүд болон гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр банкинд шууд ба шууд бусаар учирч болох эрсдэл юм. Банкны үйл ажиллагааны аль нэг түвшинд хяналт алдагдах, сулрах нь үйл ажиллагааны эрсдэлийн хамгийн гол шалтгаан болдог бөгөөд энэхүү эрсдэл нь банкийг санхүүгийн алдагдалд оруулахын дээр нэр хүндэд шууд болон шууд бусаар нөлөөлөх, эрх зүйн аливаа маргаанд банкийг татан оруулах зэрэг элдэв хүндрэлийг дагуулдаг.

Бид үйл ажиллагааны эрсдэлийг оновчтой тодорхойлох, хянаж удирдах зорилгоор холбогдох бодлого, стандарт, аргачлалуудыг боловсруулан хэрэгжүүлж байна. Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- Бизнесийн үе шат бүр дэх хариуцлага, хяналтын систем;
- Хүчирхэг дотоод хяналтын орчин;
- Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах боломж бүхий үр ашигтай бүтэц, зохион байгуулалт;
- Эрсдэлийг тодорхойлох, хянах, удирдах үйл явцыг бүхэлд нь агуулсан оновчтой үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо зэрэг юм.

Мэдээллийн аюулгүй байдал

Мэдээллийн эрсдэл гэдэг нь санаатай болон санамсаргүй байдлаар мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах, өөрчлөх, задлах, устгах замаар мэдээллийн үнэн зөв, найдвартай, хэрэглэгдэхүйц байдлыг алдагдуулах эрсдэл юм. Стратегийн өнцгөөс харвал мэдээллийн аюулгүй байдлын удирдлага нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд хамаарах онцлог үйл ажиллагаа юм. Энэ нь зөвхөн банкны мэдээллийн эх сурвалжуудыг янз бүрийн халдлагаас хамгаалаад зогсохгүй бизнесийн үйл ажиллагааг сайжруулах, бизнесийн тасралтгүй байдлыг хангах, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх болон төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд ч чухал үүргийг гүйцэтгэдэг. Бид мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэхдээ олон улсын туршлагауд болон холбогдох хууль, дүрэм, журмуудыг баримтлан ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс хэрэглэгчийн үйлдлийн бичлэгүүд, сервер болон банкны үндсэн програмын хэвийн ажиллагааны хяналтыг дотооддоо хийсэн эрсдэлийн хяналтын програмын тусламжтайгаар өдөр тутам гүйцэтгэж байна. Түүнчлэн, 2008 онд хэд хэдэн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тусгайлсан бодлого, стандартуудыг батлуулсан ба эдгээр нь банкны хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах соёлыг хэвшүүлэх, ажилтнуудыг сургахад чиглэгдсэн бодлогын баримт бичгүүд юм.

Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө

Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө нь урьдчилж хараагүй элдэв осол, саатлын улмаас банкны бизнесийн хэвийн үйл ажиллагаа тасалдахад түүнийг богино хугацаанд хэвийн байдалд нь оруулах, системийн ажиллагааг бүрэн сэргээх, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд чиглэдэг. Бид осол, саатлын үед системийг хэвийн байдалд эргүүлэн оруулах хугацааг боломжит түвшинд хамгийн богино хугацаанд байлгахыг чухалчилж, үүнтэй холбоотой банкны чадавхийг улам бэхжүүлэхийг зорин ажиллалаа.

Тайлант онд бид осол саатлын үеийн хүндрэлүүдийг удирдах үйл ажиллагааг зохион байгуулалттай, хянагдахуйц хэлбэрт оруулах зорилгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь банкны бизнесийн тасралтгүй байдлыг хянаж удирдах, уг төлөвлөгөөний биелэлтийг хангуулах үүргийг гүйцэтгэхээс гадна уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Ослын үед ажиллах баг” болон “Бизнесийн үйл ажиллагааг сэргээх баг”-ууд байгуулагдан ажиллаж байна.

Луйврын шинжтэй үйлдлүүд

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс болон Дотоод аудитын газар нь банкны хэмжээний залилан, түүнтэй төсөөтэй үйлдлүүдийг хянах, түүнээс урьдчилан сэргийлэх үүргийг гүйцэтгэдэг. Ийм төрлийн эрсдэлийн удирдлагад “Zero tolerance” аргачлалыг хэрэглэдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд ажилтнуудад захиргааны, иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж, шударга бус үйлдэл гаргасан, буруутай нь тогтоогдсон ажилтнуудын мэдээллийг ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын мэдээллийн санд бүртгэдэг. Гуравдагч этгээдийн луйврын шинжтэй үйлдлийг хууль, хүчний байгууллагатай хамтран илрүүлж, холбогдох арга хэмжээг авч байна.

Луйврын шинжтэй үйлдлүүдийн улмаас үүсэх алдагдлыг бууруулах, ийм төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкны өдөр тутмын үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар хянах, өөрчлөн зохион байгуулах, хууль хүчний байгууллагуудтай хамтран ажиллах болон хулгай, луйврын эсрэг олон улсын шалгарсан туршлагуудыг судалж нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллав.

Бодлогын хэрэгжилт

Банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дотоодын эрх зүйн зохицуулалт нь Монгол Улс болон олон улсын холбогдох гэрээ, конвенци, хуулиуд, ёс зүйн кодод нийцэж буй байдалд хяналт тавьж хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох, нэр хүндээ алдах зэрэг эрсдэлээс хамгаалах үүднээс бодлогын хэрэгжилтийн нэгж ажиллан, банкны хэмжээний эрх зүйн бичиг баримтуудад байнгын хяналт тавьж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор банкны бүхий л харилцагчийн мэдээллийг өргөтгөн, шинэчлэх ажлыг тайлант онд амжилттай хийж дуусгалаа. Энэ ажлын хүрээнд банкны өдөр тутмын гүйлгээнд хяналт тавих ажлыг автоматжуулан онлайн горимд шилжүүлсний дээр хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Албанд холбогдох тайлан мэдээг тогтмол гаргаж хамтран ажиллаж ирсэн. Мөн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын харилцагч банкуудад Голомт Банкны мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар үнэн зөв ойлголт өгөх, түүнийг бататгах, тэднээс баталгаа авах ажлыг US Patriot Act-ын дагуу хийж, хамтын ажиллагааг байнга сайжруулсаар ирсэн.

Мөн өнгөрөгч онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын баримт бичгийг өргөжүүлэн картан харилцагч элсүүлэх, хяналт тавих журмыг шинээр гарган, мөрдөж эхлэв.

Эрсдэлийн удирдлага ба хяналт (үргэлжлэл)

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, үүнтэй холбоотой банкны бодлого, журмын талаар ажилтан бүр мэдлэгтэй байх, шинэчлэгдсэн мэдээллийг цаг тухайд нь авах, өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс холбогдох сургалтуудыг тогтмол зохион байгуулж хэвшээд байна. Түүнчлэн бодлогын хэрэгжилтийн тайланг улирал бүр гарган, гүйцэтгэх удирдлага, Удирдлагын Хороо, Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаж байна.

Ажлын байрны эрүүл мэнд ба аюулгүй байдал

Ажилтнууд, харилцагчид болон бусад хамтран ажиллагсадын аюулгүй байдлыг хангах нь банкны анхаарал хандуулах асуудлуудын тэргүүн эгнээнд тавигдаж, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлд холбогдох нэгжүүд идэвхитэй ажиллаж байна. Өнгөрөгч онд ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн дүрэм журмуудыг банкны бизнесийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагатай нягт уялдуулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд голлон анхаарав.

Нийгэмд чиглэсэн арга хэмжээ



2008 онд Банк нь удаан хугацааны турш уламжлал болгож ирсэн нийгмийн сайн сайхны төлөө дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажилласан бөгөөд үүнд эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, соёл урлаг, спорт, нийгмийн хөгжил, эдийн засаг зэрэг голлох салбаруудад анхаарлаа төвлөрүүлэн ажиллалаа.

Тайлант онд Банкны нийгмийн сайн сайхны төлөө оруулсан хувь нэмрээс дурьдвал:

- Монголын Үндэсний Олимпийн Хорооны албан ёсны түнш, ерөнхий ивээн тэтгэгч банкны хувьд Монгол Улсынхаа шилдэг тамирчид, гарамгай амжилт бүхий (“Бээжин 2008” Олимпийн Наадмаас Монгол тамирчид анх удаа 2 алт, 2 мөнгөн медаль хүртсэн бахархам амжилт гаргасан юм) тамирчдаа уламжлал ёсоор дэмжин ажиллалаа;
- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 6 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, шалгарсан 100 оюутанд сургалтын тэтгэлэг олголоо;
- Монголбанктай хамтран эдийн засгийн асуудлаарх бага хурал зохион байгуулж, ивээн тэтгэгчээр ажиллалаа;
- Монголбанктай хамтран Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулж 15 тэргүүлэх их дээд сургуулийн 70 гаруй оюутан оролцлоо;
- Үндэсний Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын ивээн тэтгэгчээр ажиллав;
- Банк байгуулагдсаны 13 жилийн ойн баяраа тохиолдуулан “Үнэгүй автобус” арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд, Улаанбаатар хотын 20 гаруй мянган иргэн бүтэн өдрийн турш автобусаар үнэ төлбөргүй зорчих боломжийг олголоо;
- “Нар” хүүхдийн сэтгүүлээс зохион байгуулсан хүүхдийн гар зургийн уралдааныг ивээн тэтгэлээ;
- Их дээд сургуулийн оюутнуудад илүү боломжийг олгох зорилгоор удаан хугацаанд хамтран ажиллаж ирсэн түнш байгууллага болох Монголын Оюутны Холбооноос эрхлэн гаргасан “Монголын оюутны гарын авлага-2008” эмхэтгэлийг ивээн тэтгэлээ.

Банкнаас зохион байгуулагддаг янз бүрийн арга хэмжээ, санхүүгийн болон материаллаг дэмжлэг туслалцаа, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаануудад банкны ажилтнууд идэвхитэй хамрагдаж байна.

Банкны “Спорт хамтлаг” өмнөх жилүүдэд гаргасан амжилтаа бататгасан олон үйл явдлаар дүүрэн байлаа. Юун түрүүнд Монголын Банкны Холбооноос зохион байгуулсан хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд Банкны эрэгтэй баг мөнгөн медаль хүртлээ. Мөн банк хоорондын сагсан бөмбөгийн болон гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай оролцож 2008 оны цомын эзэн болсон бөгөөд 2009 онд дээрхи тэмцээнүүдийг зохион байгуулах хүндтэй үүргийг хүлээлээ.

Нийгэм эдийн засгийн амьдралд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бидний оруулж буй хувь нэмрийг үнэлж, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим “Шилдэг компанийн нийгмийн хариуцлагатай байгууллага” шагналаа хүртээлээ.

2008 оныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас “Нийгмийн хариуцлагын жил” болгон зарласан бөгөөд энэ ажлын хүрээнд “Ногоон оффис” аяныг нийт аж ахуй нэгжүүдийн дунд зарласан юм. Энэхүү санаачлагыг Голомт Банк дэмжиж “Ногоон оффис” аяныг бүх салбар нэгжүүдийнхээ дунд зарлаж байгаль орчинд ээлтэй, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж “Ногоон оффис” өргөмжлөлийн эзэн болсон юм.

Монголд хууль эрхзүйн орчин бүрдээгүйгээс үл хамааран Банк нь Азийн Хөгжлийн Сангаас санаачлан анх удаагаа МУИС-ийн Экологийн сургалтыг дэмжих итгэлцлийн санг байгуулахад дэмжин ажиллав. Мөн түүнчлэн томоохон харилцагч нараа дэмжих замаар Монгол улсын өмнөд бүсийн хөгжилд хувь нэмэр оруулж байна.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД:

Хадгаламж, харилцах дансны үйлчилгээ

- Харилцах данс
- Овердрафт
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хадгаламжийн сертификат
- Алтны хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- “Алтан түлхүүр” хүүхдийн хадгаламж
- Байгууллагын хадгаламж

Эскроу дансны үйлчилгээ

Зээлийн үйлчилгээ

- Байгууллагын зээл
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Зээлийн шугам
 - Хөрөнгө оруулалтын зээл
 - Хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн түрээсийн зээл
 - Банк бус санхүүгийн байгууллагын зээл
 - Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээл
 - Ашигт малтмалын зээл
 - Импортын зээл
 - Аккредитив
 - Ногоон зээл
- Төслийн зээл
 - JBIC-TSL төслийн 1-р үе шат
 - Дэлхийн банкны PSDC II төслийн зээл
 - “Атрын III” аяны зээл

Баталгаа

- Тендерийн баталгаа
- Төлбөрийн баталгаа
- Гүйцэтгэлийн баталгаа

Гадаад валютын арилжаа

Картын үйлчилгээ

- МастерКарт карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)

- Энгийн (дотоодын, олон улсын)
- Маестро (оюутны)
- Бэлгийн карт
- Виза карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Энгийн (дотоодын, олон улсын)
 - Виза электрон (оюутны)
 - Бэлгийн карт
- Американ экспресс картаар үйлчлэх

Ко-брэнд карт

- МИАТ миллэйж карт
- Airnetwork карт
- Chamber's Виза алтан карт

Е-банкны үйлчилгээ

- Интернэт банк
- Электрон банк
- SMS банк
- Е-биллинг
- Мобайл банк
- Дуудлага хүлээн авах төв
- Электрон худалдаа
- Автомат машины үйлчилгээ

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Вестерн Юнион мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Олон улсын төлбөр тооцооны үйлчилгээ
- Дотоодын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

Хувийн банкны үйлчилгээ

- Хөрөнгийн удирдлага

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Бусад үйлчилгээ

- Инкассын үйлчилгээ
- Мөнгөн шилжүүлгийг факсаар баталгаажуулах үйлчилгээ
- Дансны хуулга, тодорхойлолт гаргах үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ

ИРГЭДЭД:

Хадгаламж, харилцах дансны үйлчилгээ

- Харилцах данс
- Овердрафт
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хадгаламжийн сертификат
- Алтны хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- “Алтан түлхүүр” хүүхдийн хадгаламж

Эскроу дансны үйлчилгээ

Зээлийн үйлчилгээ

- Жижиг дунд бизнесийн зээл
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Хөрөнгө оруулалтын зээл
 - Хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн түрээсийн зээл
 - Зээлийн шугам
 - Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх зээл
 - АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл
 - Импортын зээл
 - Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн жижиг дунд бизнесийг дэмжих зээл
- Хэрэглээний зээл
 - Өрхийн зээл
 - Орон сууц засварлах зээл
 - Цалингийн зээл
 - Автомашины зээл
 - Картын зээл
 - Сургалтын зээл
 - Хадгаламж барьцаалсан зээл
 - Тэтгэвэрийн зээл
 - Шуурхай зээл
- Орон сууцны зээл
 - Өөрийн санхүүжилтээр
 - 40000 айлын орон сууц төслийн

Картын үйлчилгээ

- МастерКарт карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)

- Энгийн (дотоодын, олон улсын)
- Маестро (Оюутны)
- Бэлгийн карт
- Виза карт
 - Платинум
 - Алтан (дотоодын, олон улсын)
 - Энгийн (дотоодын, олон улсын)
 - Виза электрон (Оюутны)
 - Бэлгийн карт
- Американ экспресс картаар үйлчлэх

Ко-бренд карт

- МИАТ миллэйж карт
- Airnetwork карт
- Chamber's Виза алтан карт

Е-банкны үйлчилгээ

- Интернэт банк
- Электрон банк
- SMS банк
- Е-биллинг
- Мобайл банк
- Дуудлага хүлээн авах төв
- Электрон худалдаа
- Автомат машины үйлчилгээ

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Вестерн Юнион мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Олон улсын төлбөр тооцооны үйлчилгээ
- Дотоодын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

Хувийн банкны үйлчилгээ

- Хөрөнгийн удирдлага

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Бусад үйлчилгээ

- Инкассын үйлчилгээ
- Мөнгөн шилжүүлгийг факсаар баталгаажуулах үйлчилгээ
- Дансны хуулга, тодорхойлолт гаргах үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ

Банкны салбар нэгжүүдийн хаяг

ГОЛОМТ БАНКНЫ ТӨВ АЛБА

Бодь цамхаг, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 210620А
Утас: (976-11) 311971, 311530
Факс: (976-11) 313155, 312307
И-шуудан: mail@golomtbank.com
Вэб: http://www.golomtbank.com

УЛААНБААТАР ХОТОД БУЙ САЛБАР, НЭГЖҮҮД

Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
Төв Салбар	Худалдааны гудамж 6/2. Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас:(976-11)-310759, 313155 Факс: (976-11)-326231
Сансар Салбар	Баянцээл худалдааны төв, 15-р хороолол, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Tel: +(976-11)-456980 Fax:+ (976-11)-456829
Нисэх Тооцооны төв	“Чингэс хаан” Олон Улсын онгоцны буудал, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот	Tel:+ (976-11)-283205 Fax:+(976-11)-283205
100 айл Тооцооны төв	Сүхбаатар дүүрэг, 11-р хороолол, 7-р хороо Улаанбаатар хот	Tel: +(976-11)-350542 Fax:+ (976-11)-350544
Ард Салбар	Бага тойруу гудамж, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Tel:+ (976-11)-320712, Fax:+ (976-11)-330436
Солонго Салбар	Нацагдоржийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-320814 Факс (976-11)-318479
Саппоро Салбар	1-р хороолол, Сонгино-Хайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-681267 Факс: (976-11)-680367
Москва Салбар	Москва комплекс, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-305419 Факс: (976-11)-368602
Гааль Тооцооны төв	Хотын Гаалийн газрын байр, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-242943 Факс: (976-11)-242943
Багануур Тооцооны төв	Холбооны байр, Багануур дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-01-21)-22333 Факс: (976-01-21)-20818
Зээлийн төв	Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-330072 Факс: (976-11)-330621
Голомт хотхон Салбар	Үндсэн хуулийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-322943 Факс: (976-11)-322943
Цамбагарав Тооцооны төв	Цамбагарав худалдааны төв, 1-р хороолол, Сонгино хайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-680762 Факс: (976-11)-680763
Цэцээ гүн Тооцооны төв	“Цэцээ гүн” сургуулийн байр, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-316395 Факс: (976-11)-316395
Тэди Тооцооны төв	Самбуугийн гудамж-46, 5-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-325970 Факс: (976-11)-325970
120 мянгат Тооцооны төв	120 мянгат үйлчилгээний төв, 1-р хороо, Хан-Уул дүүрэг	Утас: (976-11)-70130080
Энхтайваны гүүр Тооцооны төв	Тээвэр үйлчилгээний төв, Чингэсийн өргөн чөлөө-11, 2-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-315949
Тамир Тооцооны төв	Ард Аюушийн гудамж, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-304959 Факс: (976-11)-304959

Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
Нарантуул Тооцооны төв	Нарантуул Олон Улсын Худалдааны төв, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-457018
Их Дэлгүүр Тооцооны төв	4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-311530, 311971 Факс: (976-11)-70111352
Чандмань Тооцооны төв	Чандмань төв, Лениний музей, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-70120520 Факс: (976-11)-70120522
Баянзүрх Тооцооны төв	15-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-458250 Факс: (976-11)-462892
Номин Тооцооны төв	Улсын Их Дэлгүүр, Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: (976-11)-313232 Факс: (976-11)-314242

ОРОН НУТАГТ БУЙ САЛБАР ТӨВҮҮД

Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
Дорнод Тооцооны төв	Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг	Утас: (976-01-582)-22703 Факс: (976-01-582)-22702
Замын-Үүд Тооцооны төв	Дорноговь аймаг, Замын үүд сум, 1-р баг	Утас: (976-025-245)-43773 Факс: (976-025-245)-43773
Орхон Салбар	Орхон аймаг, Баян-өндөр сум, Амарын талбай	Утас: 976-01-352)-25100 Факс: (976- 01-352)-22510
Орхон-Пирамид Тооцооны төв	Орхон аймаг, Баян-өндөр сум, Согоот баг	Утас: (976- 01-352)-23300 Факс: (976- 01-352)-23300
Орхон- Зээлийн төв	“Орхон-Чандмань” компанийн байр, Уурхайчин баг, Баян-өндөр сум, Орхон аймаг	Утас: (976- 01-352)-32100 Факс: (976- 01-352)-32100
Дархан Салбар	Дархан-уул аймаг. Дархан сум, 13 дугаар баг, Нийгмийн даатгалын хэлтсийн байр	Утас:(976-01-372)-27136 Факс:(976-01-372)-27136
Дархан Зээлийн төв	Дархан-уул аймаг. Дархан сум, 8 дугаар баг	Утас:(976-01-372)-27136 Факс:(976-01-372)-27136
Хөвсгөл Тооцооны төв	Хөвсгөл аймаг, Мөрөн сумын 3 дугаар хороо	Утас: (976-01-382)-21474 Факс: (976-01-382)-21474
Өмнөговь Тооцооны төв	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг	Утас: (976-01-532)-23991 Факс: (976-01-532)-23990
Ховд Салбар	Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг	Утас: (976-01-432)-22195 Факс: (976-01-432)-22195
Баян-Өлгий Салбар	Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 5-р баг	Утас: (976-01-422)-22001 Факс: (976-01-422)-22001
Дорноговь Тооцооны төв	Дорноговь аймаг, Сайншанд сум, 1-р баг	Утас: (976-01-522)-42792 Факс: (976-01-522)-42792

ГАДААДАД БУЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Нэр	Хаяг	Холбоо тогтоох утас, факс
Бээжин дэх төлөөлөгчийн газар	10E, CITIC building Tower A19, Jianguomen Dajie, Beijing. China 100004. E-mail: golomt@public2.bta.net.cn	Утас: +86 10 65033876 Факс: +86 10 65923727 Гар утас: +86 139 11737254 И-мэйл: golomt@public2.bta.net.cn
Лондон дахь төлөөлөгчийн газар	27 Throgmorton Street, London EC2N 2AQ, United Kingdom	Утас: +44 (0) 20 7382 9900 Факс: +44 (0) 20 7382 9988 И-мэйл: jemery.denton-clark@gbw.com mail@gbw.com

